

ГАРЧИГ

Гарчиг	
Ерөнхий тойм	2
1. Байгаль орчныг хамгаалах бодлогын хэрэгжилтийг хангах гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ	3-5
2. Газар, газрын хэвлийн, тусгай хамгаалалттай газар нутаг, байгаль орчны ерөнхий үнэлгээ гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ	6-10
3. Ойн ашиглалт, хамгаалалт, ойн нөхөн сэргээлт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ	11-23
4. Усны нөөцийн ашиглалт, хамгаалалт гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ	24-26
5. Амьтан ашиглалт, тоо толгойг тогтоох, агнуурын бүсүүдийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаа гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ	27-32
6. Аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээ гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр арга хэмжээ	33-45
7. Хот суурин газрын орчны бохирдлын хэмжээг бууруулах ага хэмжээ гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ	46-48
8. Байгаль орчны чиглэлийн сургалт сурталчилгаа, олон нийтийн арга хэмжээ, шинэлэг арга хэмжээ, хяналт шалгалт, мэдээллийн санг баяжуулах гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ	49-56
9. Хавсралтууд	57-128

Ерөнхий тойм

Удирдлага зохион байгуулалт, төлөвлөсөн ажлын гүйцэтгэлийн талаар

Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь 2018 онд удирдах ажилтан 2, гүйцэтгэх ажилтан 41, үйлчлэх ажилтан 4 буюу нийт 47 хүний орон тоотой ажиллаж байна.

2018 онд иргэн болон холбогдох байгууллагуудаас нийт 29 өргөдөл ирснийг хянан шийдвэрлэсэн байна.

2018 онд төрийн захиргааны байгууллага болон бусад холбогдох байгууллагаас нийт 437 албан бичиг ирснийг хүлээн авч албан хэрэг хөтлөлтийн бүртгэлд бүртгэн хяналтын карт хөтлөж шийдвэрлэлтэнд хяналт тавьж 105 хугацаатай бичгийн хариуг хүргүүлж ажиллаа. 275 албан бичгийг төр захиргааны байгууллага болон бусад байгууллагад хүргүүлсэн.

Мөн ажлын өдөр ажлын төлөвлөгөө болон гүйцэтгэлийг гарган газрын даргад танилцуулж, байгаль хамгаалагч нар сарын тайланг гэрээнд заасан хугацааны дагуу сумын Засаг даргын Тамгын газрын дарга болон байгаль орчны хяналтын улсын байцаагч хянуулан баталгаажуулан ирүүлсэн.

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын хийж гүйцэтгэсэн 7 хоногийн тайлан аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлж ажиллав.

1.1 Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Бүх нийтээр мод тарих үндэсний өдрийг зарлах тухай 63 дугаар зарлиг, Хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай 48 дугаар зарлиг, Засгийн газарт чиглэл өгөх тухай 178 дугаар зарлигийн хэрэгжилтийг хангах

2010 оны 63 дугаар зарлиг

Монгол улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигаар зарлагдсан “БҮХ НИЙТЭЭР МОД ТАРИХ ҮНДЭСНИЙ ӨДӨР”-ийг тохиолдуулан аймгийн хэмжээнд Нарс, Шинэс, Гүйлс, Хайлаас, Улиас, Хус, Бургас, Шар хуайс, Даль тэрэлж, Үхрийн нүд, Нохойн хошуу, Гүзээлзгэнэ, Монос, Өрөл, Чацаргана, Тэхийн шээг, Улаалзгана, Жигд зэрэг нийт 25.0 мянган мод таригдсан ба дээрх ажилд 3655 иргэн, 318 аж ахуйн нэгж, байгууллага оролцож 53.0 сая төгрөгийг зарцуулсан.

2014 оны 48 дугаар зарлиг

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2014 оны Хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх 48 дугаар зарлиг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн “2018 ойгоос мод бэлтгэх дээд хязгаар батлах тухай” 08 дугаар тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавих, сум болон сум дундын ой ангийн 2018 онд олгосон ойгоос мод бэлтгэх эрхийн бичиг, мод модон материалын гарал үүслийн гэрчилгээний зарцуулалт, ойн нөхөрлөл ойн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор хяналт шалгалтын ажлыг 4, 11, 12 дугаар саруудад аймгийн БОАЖГ, Цагдаагийн газар, МХГ-ууд хамтран ой бүхий сумдад бүсчлэн зохион байгууллаа. Шалгалтаар Ойн тухай хууль зөрчсөн 2 иргэнийг илрүүлэн Цагдаагийн байгууллагад шилжүүлэн, мод бэлтгэлийн 5 ойн мэргэжлийн байгууллагад МХГ-аас торгууль ноогдуулсан. Ой бүхий сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, сум болон сум дундын ойн анги хамтран хууль бус мод бэлтгэлээс урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгаа хийх, хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх хяналт шалгалтын ажлыг 114 удаа зохион байгуулан, хууль бусаар мод бэлтгэсэн, ойгоос мод бэлтгэх эрхийн бичгийн нөхцөл болзол зөрчсөн 14 удаагийн зөрчил ирүүлэн торгууль шийтгэл ноогдуулсан байна.

2013 оны 178 дугаар зарлиг

2018 онд аймгийн хэмжээнд 6.5 га талбайд ногоон байгууламж шинээр байгуулсан. Үүнд:

Мөрөн "Гэр бүл"-ийн төгөл-0.5га, Баян-Овоо сумдад "Гэр бүл" -ийн төгөл 0.2 га, "Нуггийн зөвлөлийн цэцэрлэгт хүрээлэн"-0.4 га, Дадал суманд Төв замын дагуух ногоон байгууламж-0.5 га, Бор-Өндөр суманд УБҮ-ийн дэргэд цэцэрлэгт хүрээлэн 3.24 га, Биндэр суманд төв замын дагуух 0.3 га, Норовлин сум "Улзын бага бүрд" -1.5 га, Баянмөнх сум Хэрлэн голын гүүрний далангын дагуу -0.3 га талбайд ногоон байгууламж шинээр байгуулсан.

Мөн Баян-Овоо, Цэнхэрмандал, Дадал суманд тус тус 1 га талбайд ногоон байгууламж нэмэгдүүлэх ажлыг байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаар хийж гүйцэтгэсэн.

1.2 Монгол улсын Засгийн газрын байгаль орчинтой холбоотой гарсан тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах

Монгол улсын Засгийн газрын байгаль орчинтой холбоотой гарсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэнд 25 ажил тусгагдсан бөгөөд эдгээр ажлыг 95,4 хувьтай гүйцэтгэсэн. Дэлгэрэнгүй хүснэгт-1, Хуудас 57-61

1.3 БОАЖСайдтай аймгийн Засаг даргын 2018 онд байгуулсан гэрээний хэрэгжилтийг ханган ажиллана.

Аймгийн Засаг дарга Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай 2018 онд байгуулсан гэрээнд нийт 126 ажил тусгагдсан бөгөөд 97,4 хувьтай хэрэгжүүлсэн. Дэлгэрэнгүй хүснэгт-2, Хуудас 62-101

1.4 Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт

2018 онд аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр 10 үйл ажиллагаа тусгагдсан бөгөөд 99,1 хувьтай хэрэгжүүлсэн. Дэлгэрэнгүй хүснэгт-3, Хуудас 102-106


1.4 Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт 2018 онд 26 үйл ажиллагаа тусгагдсан бөгөөд 87,4 хувьтай хэрэгжүүлсэн. Дэлгэрэнгүй хүснэгт-4, Хуудас 107-113

1.6 Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй байгаль орчны чиглэлийн үндэсний хөтөлбөр

Монгол улсын Засгийн газраас орчны чиглэлээр нийт 8 хөтөлбөрийг хэрэгжүүлж буй бөгөөд эдгээр 8 хөтөлбөрийг 2018 онд 89,5 хувьтай хэрэгжүүлсэн. Дэлгэрэнгүй хүснэгт-5, Хуудас 114-127


2.”Газар, газрын хэвлий, тусгай хамгаалалттай газар нутаг, байгаль орчны ерөнхий үнэлгээ” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ




2.1 Орон нутгийн экосистемийн тэнцвэрт байдлыг хангахад онцгой ач холбогдол бүхий газруудыг улс, аймаг, орон нутгийн тусгай хамгаалалтад авах асуудлыг хуулийн дагуу шийдвэрлүүлэх

Олсын тусгай хамгаалалтанд 9 газрын 1087186,709 га талбай буюу аймгийн нийт нутаг дэвсгэрийн 13.5 хувийг эзэлж байна. Орон нутгийн хамгаалалтанд 410 газрын 2148908.36 га буюу аймгийн нийт нутаг дэвсгэрийн 26.7 хувийг эзэлж байна. Нийт 419 газрын 3236095.069 га Аймгийн нутаг дэвсгэрийн 40.02 хувийг эзэлж байна. Мөн Улсын тусгай хамгаалалттай Онон Балжийн байгалийн цогцолборт газрын өргөтгөлийн 334921.6 га, Хар ямаатын Байгалийн нөөц газрын өргөтгөлийн 53323.8 га, Орон нутгийн хамгаалалттай Хурх Хүйтний хөндийн өргөтгөлийн 5495810,87 га, Тэнүүний сав газрын 39080 га газруудыг улсын тусгай хамгаалалтанд авахаар судалгааны ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн. Орон нутгийн зүгээс орон нутгийн иргэд сумын ИТХ-с санал авах ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна. Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр, Баян-Адрага, Дадал, Норовлин сумдын хил дамнасан Онон голын доройтсон орчныг сэргээх зорилгоор тодорхой хэсэг газруудыг орон нутгийн хамгаалалтанд авахаар тус тус төлөвлөн ажиллаж байна.

Хамгаалалтанд авахаар төлөвлөж буй газар /Зураг-1/




Улсын тусгай хамгаалалтанд авах, өргөтгөхөөр төлөвлөж буй газар /Зураг-2/



2.2 “Хэрлэн тооно” Улсын тусгай хамгаалалттай байгалийн нөөц газрын менежментийн төлөвлөгөөг эхлүүлэх.

Дэлгэрхаан сумын “Хэрлэн тооно” Улсын тусгай хамгаалалттай байгалийн нөөц газрын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг идэвхижүүлэх ажлыг ТНС олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа менежментийн төлөвлөгөөний дагуу Бөөр булгийн эхийг нутгийн иргэдийн оролцоотой хашиж хамгаалах, хамгаалалттай газар орших нөхөрлөлүүдийн бэлчээрийн даацийг тодорхойлох ажил, зэрлэг амьтанд биотехникийн арга хэмжээг иргэдийн нөхөрлөлийн оролцоотой тус тус хийж гүйцэтгэсэн.


Хэрлэн тооно улсын тусгай хамгаалалттай байгалийн нөөц газар /Зураг-3/



2.3 Аймгийн хамгаалалттай газар нутагт тэмдэгжүүлэлтийн ажил хийх

Орон нутгийн хамгаалалттай Баянхутаг суманд орших “Өвөр хөндийн” байгалийн нөөц газрын хамгаалалтыг сайжруулах зорилгоор байгаль орчныг нөхөн сэргээх зардлаар 8 сая төгрөгийн санхүүжилтээр 2018.09.24-ний өдрийн БО/2018/40 дугаартай гэрээг Цахиурт Өндөр ХХК-тай байгуулж хилийн цэсийн 17 багана, 22 тэмдэг, 3 мэдээллийн мэдээллийн самбарыг тус тус хийж газар дээр нь байрлуулан 2018.10.26-ны өдөр хүлээн авч орон нутагт нь хүлээлгэн өгсөн.

Тэмдэг тэмдэглэгээ хийж гүйцэтгэсэн газар /Зураг-4/



2.4 Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтыг сайжруулах хамгаалалтын горим, дэглэмийг тогтоож, Орчны бүсийн менежментийн төлөвлөгөөг боловсруулсан байна.

1. 2018 оны 04 сарын 02-03-ны өдөр Дорнод аймгийн Чойбалсан хотод Тосон Хулстайн байгалийн нөөц газрын хамтын менежментийн зөвлөлийн хурал зохион байгуулагдсан. Энэхүү хуралд Хэнтий, Дорнод аймгийн БОАЖГазар, УЦУОШГазар, Дорнод хамгаалалтын захиргаа, Хэрлэн голын сав газрын захиргааны дарга, мэргэжилтнүүд, Монголын байгаль орчны иргэнийн зөвлөлийн Дорнод аймгийн зохицуулагч, Норовлин, Баян-Овоо, Баянтүмэн, Хөлөнбуйр, Цагаан-Овоо сумдын ИТХ-н дарга, Засаг дарга, байгаль хамгаалагчид, нөхөрлөлийн гишүүд, ТНС хөтөлбөрийн газрын зохицуулагч, мэргэжилтнүүд буюу нийт 49 хүн оролцлоо.

2. 2018 оны 06 сарын 14-ны өдөр Улаанбаатар хотод Түмэнхаан-Шалзын орон нутгийн тусгай хамгаалалттай газрын хамтын менежментийн зөвлөлийн хурал зохион байгуулагдлаа. Энэхүү хуралд Байгалийн нөөцийн менежмент бүхий хамгаалалттай газар нутгийн сүлжээ MON/13/303 төслийн зохицуулагч, мэргэжилтнүүд, Биологийн хүрээлэнгийн эрдэмтэд, Хэнтий, Дорнод аймгийн БОАЖГазрын дарга, мэргэжилтнүүд, Дорнод УТХГазрын хамгаалалтын захиргааны төлөөлөл, Онон Балжийн УТХГазрын хамгаалалтын захиргааны төлөөлөл, Цагаан овоо, Баян-Уул, Норовлэн сумын төлөөлөл оролцсон.

3. Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, Биндэр, Батширээт, Баян-Адрага сумдын хил дамнан орон нутгийн хамгаалалттай “Хурх хүйтний хөндийн” нөөц газрын менежментийн төлөвлөгөө боловсруулах гурав дахь шатны хэлэлцүүлгийг Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газартай хамтран зохион байгууллаа. Тус хэлэлцүүлэгт Өмнөдэлгэр сумын Хурх тосгон, Биндэр сум ЗДТГазрын

ажилчид болон нөхөрлөлийн гишүүд, нөлөөлөлд өртөж болзошгүй иргэд, аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөл 40 орчим иргэн оролцож менежментийн төлөвлөгөөнд санал бодлоо тусгасан.

2.5 Ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд хяналт тавих

Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн нөхөн сэргээлт хийсэн байдалд 2 удаа тандалт судалгаа хийж гүйцэтгэсэн. Өнөөгийн байдлаар гарсан зөрчилгүй.

Он гарсаар Баян-Овоо сумын нутаг дэвсгэрт ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Ханшашир” ХХК дүйцүүлэх нөхөн сэргээлтээр 1.09 га, Айвуун тэс ХХК техникийн 5.9 га биологийн 2.9 га, Нутгийн мана ХХК 1.5 га, Шандын нуруу ХХК техникийн 4.2 га, биологийн 4,2 га талбайг аймгийн байгаль орчны нөхөн сэргээлт хүлээн авах комисст хүлээлгэн өгөөд байна

Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу 3 удаа, Засгийн газрын хамтарсан ажлын хэсэгтэй 1 удаа Батноров, Норовлин сумдын нутагт хууль бусаар байгалийн өнгөт чулуу олборлож байгаа иргэдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 55 кг өнгөт чулуу, газар ухах зориулалт бүхий багаж /хараацай гэх/ 37 ширхэг, лоом царил 11 ширхэг, хүрз 9 ширхэг, цахилгаан мотор 1ш, цахилгаан бутлагч 1 ширхэг хураан авч ажиллаа.

Хяналт шалгалтын үеийн байдал /Зураг-5/



3. “Ойн ашиглалт, хамгаалалт, ойн нөхөн сэргээлт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ



3.1 Ойн нөхөн сэргээлтийн чиглэлээр:

3.1.1 Ойжуулалтын ажил:

Улсын төсвийн хөрөнгөөр Дадал сумын Сант нэртэй газрын 40 га, орон нутгийн төсвийн хөрөнгийн Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаар Хэнтий аймгийн Баян-Адрага сумын Дуурлиг Овооны ар нэртэй газрын 20 га, Биндэр сумын Таван модны ар нэртэй газарт -8 га, Өмнөдэлгэр сумын Хурцын ар нэртэй газарт -7 га талбайд ойжуулалтын ажлыг хийж гүйцэтгэлээ. ААН-үүд өөрийн хөрөнгөөр нийт 12 га талбайд ойжуулалтын ажил хийсэн. Мөн Дэлхийн байгаль хамгаалах сантай хамтран хэрэгжүүлж байгаа “Мод дагаж ус-Ус дагаж амьдрал” аяны хүрээнд Норовлин сумын 10 га нийт 97 га талбайд нарс, шинэс модны тарьцаар ойжуулалт хийгдлээ. Амьдралт 75-95% -тай байна.

2018 онд хийгдсэн ойжуулалтын ажлын жагсаалт

/ Хүснэгт -6/

№	Сумын нэр	ААНБ, Нөхөрлөлийн нэр	Газрын нэр	Талбайн хэмжээ /га/	Төсөв
1	Биндэр	“Биндэр-Ой” СДОА	Таван модны ар	8.0	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр
		“Дэлгэр-Онон” нөхөрлөл	Шанаган толгойн ар	2.0	Өөрийн хөрөнгөөр
		“Яргуй” нөхөрлөл	Хайлааст	1.0	Өөрийн хөрөнгөөр
		дүн		11.0	
2	Өмнөдэлгэр	“Хэнтийн шинэс” СДОА	Хурцын ар	7.0	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр
		"Модон цаг" ХХК	Морин давааны ар	5.0	Өөрийн хөрөнгөөр
		дүн		12.0	
3	Баян-Адрага	"Хурхнагжибур" ХХК	Дуурлиг овооны ар	20.0	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр
		дүн		20.0	
4	Дадал	“Тэнгэрлэг ой” ХХК	Сант	40.0	
		Дэлхийн байгаль хамгаалах сан	Ёлын арын хүзүүвч	1.0	Өөрийн хөрөнгөөр
		“Цагаан булаг андууд” ХХК	Сант	3.0	Өөрийн хөрөнгөөр
		дүн		44.0	
5	Норовлин	WWF, Сумын иргэд	Хөндлөн	10.0	Өөрийн хөрөнгөөр
				10.0	
Нийт дүн			Улсын төсөв	40.0	
			Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	35.0	
			Өөрийн хөрөнгөөр	22.0	
			дүн	97.0	

Өмнөдэлгэр, Батширээт сумдад хийгдсэн ойжуулалтын ажил / Зураг-6/



3.1.2 Байгалийн сэргэн ургалтанд туслах ажил:

Орон нутгийн төсвийн хөрөнгийн Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаар Батширээт сумын Уужийн булаг, Гурван даваа нэртэй газар 10 га, Өмнөдэлгэр сумын Тариатын ам нэртэй газарт 10 га, Биндэр сумын Байц нэртэй газарт 10 га нийт 30 га талбайд байгалийн сэргэн ургалтанд туслах ажил батлагдсан.

Тус ажлыг “Батширээт” СДОА, “Хэнтийн шинэс” СДОА, “Биндэр-Ой” СДОА –иудтай тус тус гэрээ байгуулж ажлыг гүйцэтгүүлсэн.

Биндэр суманд хийгдсэн байгалийн сэргэн ургалтанд туслах ажил /Зураг-7/



3.1.3 Ногоон байгууламж нэмэгдүүлэх болон мод тарих аяныг зохион байгуулах ажил:

Монгол улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигаар зарлагдсан “БҮХ НИЙТЭЭР МОД ТАРИХ ҮНДЭСНИЙ ӨДӨР”-ийг тохиолдуулан аймгийн хэмжээнд Нарс, Шинэс, Гүйлс, Хайлаас, Улиас, Хус, Бургас, Шар хуайс, Даль тэрэлж, Үхрийн нүд, Нохойн хошуу, Гүзээлзгэнэ, Монос, Өрөл, Чацаргана, Тэхийн шээг, Улаалзгана, Жигд зэрэг нийт 25.0 мянган мод таригдсан ба дээрх ажилд 3655 иргэн, 318 аж ахуйн нэгж, байгууллага оролцож 53.0 сая төгрөгийг зарцуулсан.

Хээрийн бүсийн сумдууд болон Чингис хотын модны тарьц суулгацын хэрэгцээг хангах зорилгоор “МОДНЫ ТАРЬЦ, СУУЛГАЦ -2018” худалдааг зохион байгууллаа. Үзэсгэлэн худалдаагаар Нарс, Шинэс, Гүйлс, Хайлаас, Улиас, Хус, Бургас, Шар хуайс, Даль тэрэлж, Үхрийн нүд, Нохойн хошуу, Гүзээлзгэнэ, Монос, Өрөл, Чацаргана, Тэхийн шээг, Улаалзгана, Жигд зэрэг нийт 20 гаруй зүйлийн модны суулгац, үр бордоо худалдаалагдав.

Хэнтий аймгийн Хүүхэд залуучдын цэцэрлэгт хүрээлэнд мод тарьж тохижилтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Тохижилтын ажилд БОАЖГ, Батширээт, Биндэр, Хэнтий шинэс СДОА-ууд болон Цэнхэрмандал сумын ойн ангийн инженер техникийн ажилтнууд оролцож зохион байгуулсан. Тохижуулах ажилд 200 ширхэг нь нарс, 120 ширхэг Гүйлс, 250 ширхэг Шар хуайс, 430 ширхэг хайлаас, нийт 1000 ширхэг мод тарьсан. Амьдралт 60 % тай ургаж байгаа ба 2019 онд нөхөн тарилт хийнэ.

Ногоон байгууламж нэмэгдүүлэх болон мод тарих аян /Зураг-8/



2018 онд аймгийн хэмжээнд шинээр 6.2 га талбайд ногоон байгууламж байгуулагдсан. Үүнд: Мөрөн "Гэр бүл"-ийн төгөл-0.5 га, Баян-Овоо сумдад "Гэр бүл" -ийн төгөл-0.2, "Нутгийн зөвлөлийн цэцэрлэгт хүрээлэн"-0.4 га, Дадал суманд Төв замын дагуух ногоон байгууламж-0.5 га, Бор-Өндөр суманд УБҮ-ийн дэргэд цэцэрлэгт хүрээлэн 3.24 га, Биндэр суманд төв замын дагуух 0.03 га, Норовлин сум "Улзын бага бүрд" -1.5 га, Баянмөнх сум Хэрлэн голын гүүрний далангын дагуу -0.03 га талбайд ногоон байгууламж шинээр байгуулагдлаа.

Мөн Дадал, Баян-Овоо, Цэнхэрмандал сумдын 3 га газарт ОНТХ-н Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлын 15,0 сая төгрөгөөр ногоон байгууламж байгууллаа.

Ногоон байгууламж нэмэгдүүлэх болон мод тарих аян /Зураг-9/



Хэрлэн сумын “Өндөрхаан хот тохижилт” ОНТҮГ -ийн бүтэц орон тоонд Ногоон байгууламжийн тасгийг байгуулсан ба техникийн дэмжлэг үзүүлж усалгааны зориулалтаар тоногдсон автомашин авахад БХНСЗ-аас 20.0 төгрөг зарцууллаа.

Ногоон байгууламж нэмэгдүүлэх болон мод тарих аян /Зураг-9/



3.1.4 Мод үржүүлгийн ажил:

Аймгийн хэмжээнд нийт Хэнтий шинэс СДОА, Биндэр-Ой СДОА, Батширээт СДОА -иудын мод үржүүлгийн газарт 1-3 насны нийт 4152.0 мянган навчит болон шилмүүст модны тарьц суулгац ургаж

байна. Үүн дээр нэмж 2018 онд шилмүүст модны 33 кг, навчит модны 5 кг үрийн тарилтыг хийж тарьц суулгацын нөөцөө нэмэгдүүлэх арга хэмжээ авч байна.

Дадал суманд байрлах Онон мөрний нөхөрлөлүүдийн нэгдсэн холбооны "Хүрэн шугуй" мод үржүүлгийн газарт усалгааны систем тавих өргөтгөлийн ажлыг орон нутгийн төсвийн хөрөнгийн Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлын 5.0 сая төгрөгөөр санхүүжүүлсэн. Гүйцэтгэгчээр Онон мөрний нөхөрлөлүүдийн нэгдсэн холбоо ажиллаа.

Ойгоос хууль бусаар мод шилжүүлэн суулгах үйлдлийг зогсоох зорилгоор мод үржүүлгийн газарт ургаж байгаа шилмүүст модны суургац бүрийг тэмдэгжүүлэх ажлыг 2018 оноос эхлүүлж байна. БОАЖГ – ХЭ /0001 -5000/ бичвэртэй нэг удаагийн түгжээтэй лацыг талбайд байгаа шилмүүст модны гол ишинд зүүж тэмдэглэв. Орон нутаг болон Улаанбаатар хотруу суулгац тээвэрлэхэд зөвхөн мод үржүүлгийн газраас тээвэрлэж байгааг илэрхийлэх юм. Лац тэмдэглээгүй суулгац худалдаанд гарахгүй юм.

Лац тэмдэглэгээ/Зураг-10/



3.2 Ой хамгаалалын чиглэлээр:

3.2.1 Ой хээрийн түймрийн талаарх мэдээлэл:

2018 оны жилийн эцсийн байдлаар Баянхутаг суманд 2, Өмнөдэлгэр суманд 1, Норовлин суманд 2, Батширээт суманд 2, Дадал суманд 2, Баян-Овоо суманд 1, Хэрлэн суманд 1 нийт 11 удаагийн ой хээрийн түймэр гарч өмнөх оны мөн үеэс 15% -иар буурсан үзүүлэлттэй гарсан байна. Дээрхи ой хээрийн түймрийн улмаас 240 га ой сангийн талбай, 2315 га бэлчээрийн талбай нийт 2555 га талбай түймэрт өртөн байгаль экологид 139,0 сая.төг, эд материалын хохирол 5,2 сая.төг-ийн хохирол учирч, түймэр унтраах шууд зардалд 7,7 сая.төг-ийг зарцуулсан байна. Түймэр гарсан шалтгааныг авч үзвэл иргэдийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалсан 4, аянганаас 2, эзэн шалтгаан тогтоогдоогүй 5 удаагийн түймэр гарч эзэн холбогдогчтой ой хээрийн түймрийн экологийн хохирол 27%, эд материалын хохирол 100%, түймэр унтраах шууд зардал 100% тус тус төлөгдсөн байна. /График-1 /

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын зүгээс Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаас ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 2018 онд нийт 36,5 сая төгрөгийг зарцуулахаар шийвэрлэж ажлын гүйцэтгэл 100 %-тай биелэгдсэн. Мөн төсөл хөтөлбөрөөс 20,0 сая төгрөгөөр сургалт сурталчилгааны ажлыг хийж гүйцэтгэлээ. **Шуурхай бүлэг**

Хаврын хуурайшилтын улиралд аймгийн Онцгой байдлын газартай хамтран ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах шуурхай бүлгийг 24 хүний бүрэлдэхүүнтэй түймрийн эрсдэл өндөртэй Биндэр, Норовлин сумдад 4-5 саруудад 1 сарын хугацаанд байршуулан ажиллуулсан. /График-1/



3.2.1.1 Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг

Аймгийн ЗДТГ, БОАЖГ, ОБГ хамтран “Аймгийн Засаг даргын нэрэмжит” гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг 2018 оны 3 сард 18 сум 5 тосгоны хэмжээнд зохион байгуулж сумдын гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн, ой хээрийн түймэртэй тэмцэх 1,2,3 –р ээлжийн бие бүрэлдэхүүн, машин техник, тоног төхөөрөмжийн томилгоог шалгаж, Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Ойн тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Засгийн газрын 2013 оны 106 дугаар тогтоолын дагуу мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг /Зураг-11/



3.2.1.2 Харлуулсан шороон зурвас

Хил дамнасан түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2013-2016 онд хилийн бүс нутаг болох Дадал, Биндэр сумдад түймрээс хамгаалах 175 км урттай, 10 м өргөнтэй харлуулсан шороон зурвас байгуулагдсан. Дээрхи зурвасыг 2017 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр хилийн зурваст хилийн шугамын дагуу 30 км урттай газрыг 10 метрийн өргөнтэй, 28 км газрыг 20 метрийн шинээр хагалж нийт 86 км газрыг шинээр зурвас байгуулсан. Сүүлийн 3 жилд хил дамнасан ой хээрийн түймэр хилийн бүс нутагт гараагүй болно.

2018 онд зурваст хилийн шугамын дагуу 30 км урттай газрыг 10 метрийн өргөнтэй, 28 км газрыг 20 метрийн шинээр хагалж зурвасны өргөнийг нэмэгдүүлэхээр Хилийн 0287 ангитай гэрээ байгуулан 20.0 сая төг-ийн санхүүжилтээр гүйцэтгүүлсэн.

Харлуулсан шороон зурвас/Зураг-12/



3.2.1.3 Сургалт сурталчилгаа, хяналт

1. Аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний газраас гаргадаг хуурайшилтийн үеийн зэрэглэлийн мэдээ, www.icc.mn цахим сайтны хиймэл дагуулын сансрын зургийн мэдээ мэдээллийг Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар болон нийт сумдууд үйл ажиллагаандаа тогтмол авч ашиглаж байна.

2. НУБ-ын ХХААБ-ын “Ой бүхий аймгуудын биологийн олон янз байдлын хамгаалал, тогтвортой ойн менежмент, нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэх нь” төслөөс аймгийн БОАЖГ, ОБГ-тай хамтран “Ой хээрийн түймрийн эрсдэлийг бууруулах” сургалтыг 2018 оны 4, 10 дугаар саруудад Дадал, Биндэр, Өмнөдэлгэр сумд гэсэн 3 бүсэд 2 удаа сургалтыг зохион байгууллаа. Сургалтыг Хэнтий аймгийн Онцгой байдлын газрын ахлах дэслэгч Х.Эрдэнэбат, ахлах ахлагч Ц.Төмөрбаатар, БОАЖГ-н Ойн албаны мэргэжилтэн Э.Батсайхан нарын бүрэлдэхүүнтэйгээр бүхий 8 сумын ЗДТГ, сумдын нөхөрлөлийн холбоо, ойн нөхөрлөлийн 220 гишүүд, Цэнхэрмандал, Өмнөдэлгэр сумдын сайн дурын 20 гишүүдийг хамруулсан нийт 260 оролцогчдод Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх багаж тоног төхөөрөмжийг

Ой хээрийн түймрийн хуурайшилтийн үед ой бүхий сумдын байгаль хамгаалагч нар ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 43 удаа хийж, 9 удаагийн зөрчил ирүүлж, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх анхааруулга санамжийг 1875 иргэн, 997 айл өрх, түймэр гаргахгүй гэсэн баталгааг 726 иргэнээр гаргуулсан байна.

3.2.2 Ойн хөнөөлт шавьжийн талаарх мэдээлэл:

Улсын төсвийн хөрөнгөөр нийт 37.5 мянган га талбайд ойн хөнөөлт шавьжийн тэмцлийн ажил хийгдэхээр төлөвлөгдсөн. Тэмцлийн өмнөх судалгааг Ойн судалгаа хөгжлийн төв, Биосфер экологийн нийгэмлэгтэй гэрээ байгуулсаны дагуу Хэнтий аймгийн ой бүхий 8 сумын нутгаар хийж, судалгааны дүнд тэмцэл хийх шаардлагатай талбай 24.7 мян.га байгааг тогтоосон. Мөн намрын судалгааны ажлыг 9 р сард хийсэн ба судалгаагаар тэмцэл хийх шаардлагатай голомтой талбай Өмнөдэлгэр, Цэнхэрмандал сумдад 8,0 мян.га байгааг тогтоосон.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 оны 06, 09 саруудад “Хатан форест” ХХК тэмцлийн ажлыг агаарын хөлгөөр хийж гүйцэтгэсэн. Өмнөдэлгэр, Биндэр суманд 3600 га талбайд яacobсоны төөлүүрч эрвээхэйн, Цэнхэрмандал, Өмнөдэлгэр суманд 8000 га талбайд сибирийн хүрийн устгалын ажил хийгдсэн.

Орон нутгийн төсвийн хөрөнгийн Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаар Цэнхэрмандал сумын Мөнхийн жалга нэртэй газрын 1000 га талбайд тэмцлийн ажлыг Цэнхэрмандал сумын ойн анги хийж гүйцэтгэсэн. Нийт 12600 га талбайд тэмцлийн ажил хийгдсэн.

Ойн хөнөөлт шавьжтай тэмцэх ажил /Зураг-15/



3.2.3 Цаг агаарт зориудаар нөлөөлөх арга хэмжээ:

Орон нутгийн төсвийн хөрөнгийн байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаас 2018 онд 9,5 сая төгрөгийг цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсний дагуу аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний газартай гэрээ байгуулж гэрээний хэрэгжилтийг хангуулан ажиллаа. Цаг агаарт зориудаар нөлөөлөх "Хэрлэн-бороо экспедиц" 2018 оны 4 -7 сард цаг агаарын нөхцөл бүрдсэн 13 процессод, 3 экспедиц давхардсан тоогоор 21 удаа тунадас нэмэгдүүлж ажиллаа. Үүнээс газар тариалангийн бүсэд 7 удаа, ойн түймрийг унтраахад дэмжлэг үзүүлэхэд 2 удаа, отрын бүсэд 2 удаа, бэлчээрийн бүс нутгаар 10 удаа тус тус тунадас нэмэгдүүлсэн.

Цаг агаарт зориудаар нөлөөлөх арга хэмжээ /Зураг-16/




3.3 Ой ашиглалтын чиглэлээр:

3.3.1 Ой ашиглалт:


2018 оны жилийн эцсийн байдлаар үйлдвэрлэлийн ашиглалтаар 688м³, арчилгааны огтлолтоор 284м³, цэвэрлэгээний огтлолтоор 10600м³, цэвэрлэгээний ажлаар 15750 м³, уламжлалт бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор 1695м³ нийт 31780 м³ мод бэлтгээд байна. Үнээс хэрэглээ 9700 м³, түлээ 22080 м³ модыг бэлтгэж, мод бэлтгэлийг 35%-тай гүйцэтгэсэн байна. /График-2/

График-2



Ой бүхий сумдын ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогоос Өмнөдэлгэр суманд-28,1 сая, Цэнхэрмандал суманд -19,8 сая, Биндэр суманд -39,5 сая, Норовлин суманд-10,8 сая, Баян-Адрага суманд 7,9 сая, Батширээт суманд -35,4 сая, Дадал суманд -34,1 сая, Жаргалтхаан суманд -2,3 сая нийт аймгийн хэмжээнд 177,2 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлж ойн орлогын гүйцэтгэл 78%-тай байна./ График-3, Хүснэгт-7/

График-3



3.3.2 Хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх ажлын хүрээнд

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 48 дугаар зарлиг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн “2018 ойгоос мод бэлтгэх дээд хязгаар батлах тухай” 08 дугаар тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавих, сум болон сум дундын ой ангийн 2018 онд олгосон ойгоос мод бэлтгэх эрхийн бичиг, мод модон материалын гарал үүслийн гэрчилгээний зарцуулалт, ойн нөхөрлөл ойн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор хяналт шалгалтын ажлыг 4, 11, 12 дугаар саруудад аймгийн БОАЖГ, Цагдаагийн газар, МХГ-ууд хамтран ой бүхий сумдад бүсчлэн зохион байгууллаа. Шалгалтаар Ойн тухай хууль зөрчсөн 2 иргэнийг илрүүлэн Цагдаагийн байгууллагад шилжүүлэн, мод бэлтгэлийн 5 ойн мэргэжлийн байгууллагад МХГ-аас торгууль ноогдуулсан.

Хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх ажил /Зураг-17/



Ой бүхий сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, сум болон сум дундын ойн анги хамтран хууль бус мод бэлтгэлээс урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгаа хийх, хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх хяналт шалгалтын ажлыг 114 удаа зохион байгуулан, хууль бусаар мод бэлтгэсэн, ойгоос мод бэлтгэх эрхийн бичгийн нөхцөл болзол зөрчсөн 14 удаагийн зөрчил ирүүлэн торгууль шийтгэл ноогдуулсан байна.

Хэнтий аймгийн хэмжээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2014 оны 48 дугаар зарлигийн хүрээнд хийгдсэн ажлын товч тайлан /Хүснэгт-8/

№	Сумын нэр	Шалгалтын тоо	Илрүүлсэн зөрчлийн тоо	Захиргааны арга хэмжээ, торгууль /төг/	Нөхөн төлбөр /төг/	Хураагдсан мод модон, бүтээгдэхүүний хэмжээ /м ³ /	Цагдаагийн байгууллагад шилжүүлсэн зөрчлийн тоо
1	Батширээт	8	-	-	-	-	-
2	Биндэр	9	3	900000	-	-	-
3	Баян-Адрага	6	1	-	-	9	-
4	Дадал	36	1	300000	-	-	-
5	Дэлгэрхаан	5	-	-	-	-	-
6	Жаргалтхаан	5	3	3176400	-	11	2
7	Норовлин	28	1	300000	-	-	-
8	Өмнөдэлгэр	4	-	-	-	3	-
9	Цэнхэрмандал	13	5	1500000	4020000	46.4	3
	Нийт дүн	114	14	6176400	4020000	69.4	5

4. "Усны нөөцийн ашиглалт, хамгаалалт" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ



4.1. Ус ашиглалтын үйл ажиллагааг сайжруулах ажлын хүрээнд:

Аймгийн хэмжээний ус ашиглагч байгууллагуудын ус ашиглалтад аймгийн Аудитын газраас хяналт шалгалтын ажлыг явуулан зөвлөмжийг Байгаль орчин аялал жуулчлалын газарт ирүүлсэн. 2018 оны байдлаар 14 аж ахуйн нэгжид ус ашиглалтын дүгнэлтийг гаргаж, 6 аж ахуйн нэгжтэй ус ашиглуулах гэрээ байгуулан ажиллалаа.

4.2. Усны нөөцийн хамгаалалтын ажлыг сайжруулах ажлын хүрээнд:

1. Хэрлэн голын нөөц горим тогтоох зорилгоор Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн дарга Л.Чулуунтай зөвшилцснөөр Баянмөнхийн гүүрэнд гадаргын усны төвшин хэмжигч автомат багаж суурилуулах ажлыг Олсолюшн ХХК-аар гүйцэтгүүлсэн.

Төвшин хэмжигч автомат багаж /Зураг-18/



2. Усны чанарын хяналтын тогтолцоог бий болгох зорилгоор Баян-Овоо, Баянхутаг сумдад төвийн ундны худагт ус цэвэршүүлэх төхөөрөмжийг Ирмүүн бармат ХХК-аар гүйцэтгүүлэн суурилуулсан. Уг төхөөрөмж нь усыг электрон буюу цахилгаан соронзон аргаар усны хатуулгийг зөөлрүүлэх багаж юм.

Ус цэвэршүүлэх төхөөрөмж /Зураг-19/



3. 2016 онд аймгийн ИТХ-ын 13-р тогтоолоор усан сан бүхий газрын онцгой, энгийн, эрүүл ахуйн бүсийн хилийн цэсийг баталсан. 2018 онд Цэнхэрмандал, Дэлгэрхаан, Мөрөн, Хэрлэн, Баянхутаг сумдын нутагт орших Хэрлэн голын дагуу голоос 50м-т хамгаалалтын бүсийн нийт 43 тэмдэглэл бүхий самбарыг суурилуулсан.

Тэмдэгжүүлэх самбар /Зураг-20/




4. Усан сан бүхий газрын цэвэрлэгээг 5, 10-р саруудад зохион байгуулсан бөгөөд 3418,0 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулсан байна. Аймгийн хэмжээнд нийт 37 тн хог хаягдлыг цэвэрлэж, Хэрлэн гол болон Улз голын орчимд 10ш хогийн сав байршуулсан.




Хэрлэн, Улз голын орчимд байршуулсан хогийн сав /Зураг-21/

5. Аймгийн хэмжээнд нийт 8 булгийн эхийг хашиж, 4 булгийн хашааг сэргээн зассан. Норовлин сум Бага бүрдийн эхийг хашиж, Өндөр дов, Мөстийн булгийн эхийг сэргээн зассан. Хэрлэн сум Чулуутын булаг, Өвдгийн булгийн эхийг хашиж хамгаалсан. Баян-Овоо суманд Мухар булгийн хашааг сэргээсэн. Дэлгэрхаан суманд Бөөр булгийн эхийг хашаажуулсан. Цэнхэрмандал сумын Тосонгийн амны адгийн булаг, Бургастайн амны булаг, Өмнөдэлгэр сумын Зүрхийн булаг, Мөрөн сумын Эхэн ус, Рашаант булгийн эхийг хамгаалсан.

Булгийн эхийг хашаажуулалт /Зураг-22/



5.”Амьтан ашиглалт, тоо толгойг тогтоох, агнуурын бүсүүдийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаа” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ



5.1 Амьтны нөөцийн ашиглалтын хүрээнд

1. 2018 оны 2-р сарын 7-ны өдрийн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын долдугаар хуралдааны 1-р тогтоолоор Хэнтий аймгийн хэмжээнд 2018 онд ахуйн болон тусгай зориулалтаар агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээний дээд хэмжээг тогтоосон.

2. 2018 онд ангийн нөөц ашигласны төлбөрийн орлого 285,5 сая төгрөг төвлөрөхөөс жилийн эцсийн байдлаар 540,2 сая төгрөг төвлөрсөн.

3. Хэнтий аймгийн хэмжээнд 2018 онд тусгай зориулалтаар 4 толгой угалз, 5 толгой цагаан зээр, 150 толгой шувуу, 82 толгой тул загас, 1320 толгой бусад загас, 51 толгой идлэг шонхор агнуулж бариулсан. Ахуйн зориулалтаар 6 толгой бор гөрөөс, 850 толгой загас, 26 толгой зэрлэг гахай, 14 толгой цагаан зээр агнуулж бариулсан.

5.2 Амьтны нөөцийн хамгаалалтын хүрээнд

5.2.1. Ховор амьтдад биотехникийн арга хэмжээ авав

Аймгийн хэмжээнд зэрлэг амьтдад нутагшдаг 12 сум, нэг Улсын тусгай хамгаалалттай газарт 1230 боодол өвс, 45 тн хужир, 3 шуудай хивэг, 300кг ашигт долооц, 20 боодол тэжээлийн ургамал тавьсан. 37 цэгт мониторинг ажиглалт судалгаа хийсэн. /БХНСЗ-аас 28,4 сая төгрөг зарцуулсан/

Үүнд:

1. Галшар сумын ховор амьтад нутагшдаг газруудад биотехникийн арга хэмжээ авах БО/2018/02-01 гэрээг /Байгаль хамгаалах зардлаар 1 сая.төгрөг/ Баянхаан нөхөрлөлтэй байгуулан ажлыг гүйцэтгэсэн. Галшар уул, Их Арт, Бага Арт, Үнэгд ууланд 3-р сард ажлын хэсэг 32 боодол өвс, 3,6 тн хужир тавьсан.

Галиар сум биотехникийн арга хэмжээ /Зураг-23/



2. Бор-Өндөр сумын ховор амьтад нутагшдаг газруудад биотехникийн арга хэмжээ авах БО/2018/02-02 гэрээг/Байгаль хамгаалах зардлаар 1 сая.төгрөг/ иргэн Х.Дарханбаатартай байгуулан ажлыг гүйцэтгэсэн. Бор-Өндөр, Өлгий уул, Адаг уул, Зугаалгын хад гэх газруудад 4-р сард 120 боодол өвс, 1тн хужир тавьсан.

3. Мөрөн сумын ховор амьтад нутагшдаг газруудад биотехникийн арга хэмжээ авах БО/2018/02-06 гэрээг/Байгаль хамгаалах зардлаар 1 сая.төгрөг/ иргэн Э.Дашдаваатай байгуулан ажлыг гүйцэтгэсэн. Гамал, Өндөрхаан, Салбар ууланд 4 сарын 15-нд 6тн хужир тавин 4 сарын 24-нд мониторинг судалгаа БОХУБ, байгаль хамгаалагч нар хийсэн.



Мөрөн сум биотехникийн арга хэмжээ /Зураг-24/



4. Хэрлэн сумын ховор амьтад нутагшдаг газруудад биотехникийн арга хэмжээ авах БО/2018/02-04 гэрээг/Байгаль хамгаалах зардлаар 1 сая.төгрөг/ иргэн Б.Түвшинбаатартай байгуулан ажлыг гүйцэтгэсэн. Хайлантай, Хутаг ууланд 4-р сард 2,2тн хужир тавьсан.

5. Онон Балжийн байгалийн цогцолборт газрын зэрлэг амьтдад биотехникийн арга хэмжээ авах 2018/03 гэрээг /Байгаль хамгаалах зардлаар 10 сая.төгрөг/ Өнөрчийн гол ХХК-тай байгуулан ажлыг гүйцэтгэсэн. Биотехникийн арга хэмжээг гэрээнд тусгагдсан дараах газруудад 2018 оны 03 дугаар сарын 24-ноос 31-ны өдрүүдэд хийж гүйцэтгэлээ. Үүнд: Онон-Балжийн БЦГ-ын “А” хэсэг буюу Харгиастай, Баянголын эх, Тосон, Буурлын шивэр, Буягтын шивэр, Хүйтэн булаг, Байцын даваа, Бугатын нуур, Зуун модны шивэр, Хүйтэн булаг, Байцын даваа, Бугатын нуур, Тахир, Тожигийн овоо, Хүрхрээ, Баянцагаан, Өл, Бүрд гол, Улиастай, Агуйт, Талын гол, Ноён даваа, Тэнхлэгийн эх, Сөөгтэйн эх, Тариат гэх нийт 22 цэгт, Онон-Балжийн БЦГ-ын “Б” хэсэгт Эмгэнт, Улаалзаргана, Түмэн хоньт, Гозуултай, Нирхрүү, Агацын адаг, Цагаан арал, Чулуутын гарам, Жорновой, Асгатын адаг зэрэг 10 цэгт зэрлэг ан амьтдад 3.9тн хужир, 460 боодол өвс тавьсан. 37 цэгт мониторинг хийсэн.

Онон Балж БЦГазарт биотехникийн арга хэмжээ /Зураг-25/



6.2018.01.09 өдөр БОХУБ, байгаль хамгаалагч нар Өмнөдэлгэр сумын Барууны овоо, Өвөртийн энгэр гэх газруудад нутагшдаг аргаль, бор гөрөөсөнд 3 шуудай хивэг, 15 боодол өвс тавьж өгсөн.

Өмнөдэлгэр сум биотехникийн арга хэмжээ /Зураг-26/



7. 2018 оны 02 душаар сарын 07-09 –ны өдрүүдэд Баянхутаг сумын Баян ууланд “Ханомаро тур” ХХК-тай сумын ЗДТГазар хамтран 4 тн хужир шүү, 20 боодол өвс, 300кг ашигт долооц тавьсан./БХЗ- 0,4 сая төгрөг, агнуурын бүс хариуцагчаас 1,2 сая төгрөг/

Баянхутаг сум биотехникийн арга хэмжээ /Зураг-27/



5.Жаргалтхаан сумын Чулуут багийн нутаг Дэлгэр-Овоо, Дарийн даваа гэх газруудад 2,5тн хужир, 40 ширхэг боодлын ногоон өвс, 20 ширхэг сломыг/тэжээлийн өвс/ тавьж өгсөн./БХЗ- 0,5 сая төгрөг/

5.2.2.Монгол тарвага сэргээн нутагшуулна

Баянхутаг сумын агнуурын бүс нутаг Баянхүрээ ууланд 30 толгой, Дадал сумын агнуурын бүс нутаг Агац Гилбэр гэх газарт 15 толгой Монгол тарвага сэргээн нутагшуулах ажлыг 7-9-р сард хийхээр төлөвлөн нягтшил өндөртэй тарваган тахал өвчний голомтгүй газраас барихаар тусгай зөвшөөрлийн хүсэлтийг БОАЖЯ-д хүргүүлсэн.

5.2.3 Мониторинг ажиглалт судалгаа

2018 онд аймгийн хэмжээнд байгаль хамгаалах зардал 3,6 сая төгрөгөөр нийт 3 суманд зэрлэг амьтдын мониторинг ажиглалт судалгааг, GCP/MON/008/GFF төслийн санхүүжилтээр 5 суманд зэрлэг амьтдын ул мөрийг тэмдэглэх сургалтыг тус тус зохион байгуулсан.

Үүнд:

1. Дадал сум Цээнэтэй, Агац Гилбэр агнуурын бүсүүдэд мониторинг ажиглалт судалгаа/агнуур зохион байгуулалт/ Уламжлалт ав ХХК-тай хийлгэхээр 2018.05.20-ны өдөр сумын Засаг дарга гэрээ байгуулсан. Гэрээний дагуу Уламжлалт ав ХХК нь Дадал сумын Цээнэтэй, Агац Гилбэр агнуурын бүсүүдэд мониторинг ажиглалт судалгааг хийн сумын ИТХ-аар хэлэлцүүлж аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас хянуулан Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлээд байна. БХЗ-с 2,8 сая төгрөг зарцуулсан.

2. Норовлин сумын Нарстай, Хөх Асгана, Түмэнхаан, Энгэрбулаг, Бэрх нөхөрлөлийн 11 гишүүн, идэвхтэн байгаль хамгаалагч нарт тарваганы мониторинг ажиглалт судалгаа хийх дадлага ажлыг зохион байгуулсан. БХЗ-0,5 сая төгрөг зарцуулсан.

3. Баянмөнх сумын Язаар уул орчмын агнуурын бүс нутагт Язаарын 3 овоот нөхөрлөл, БОХУБайцаагч, байгаль хамгаалагч нар хамтран 2018.05.08-нд ховор амьтдад тооллого зохион байгуулсан. Тооллогоор Их салхит, Бага салхит, Дөрвөлжин, Гурван овоот, Барчгар, Дулаан, Агуйт, Баруун дөрвөлжин зэрэг газрууд хамрагдсан. Тооллогоор 8 угалз, 21 хонь, 18 хурга, 2 буга тус тус тоологдсон. БХЗ-340000 төгрөг зарцуулсан.

4. Ой бүхий аймгуудын биологийн олон янз байдлын хамгаалал, тогтвортой ойн менежмент, нүүрстөрөгчийн хийн хуримтлалыг нэмэгдүүлэх GCP/MON/008/GFF төсөл, Биологийн хүрээлэн, аймгийн БОАЖГазар хамтран 2018.05.09-2018.05.15-ны өдрүүдэд Цэнхэрмандал сумын Буурал Юдэг, Өмнөдэлгэр сумын Тэнүүн, Батширээт сумын Согоот, Биндэр сумын Хөмөл Балж, Дадал сумын Сэрүүнбаялаг, Баянцагаан нөхөрлөлийн 50 гишүүнд Зэрлэг амьтдын мониторинг ажиглалтын судалгаа хийх сургалтыг зохион байгуулан ажиглалтын талбайд ажиглагдсан амьтдыг газарзүйн мэдээллийн санд оруулсан.

Нөхөрлөлийн талбайд мониторингийн сургалт хийв /Зураг-28/



5.2.4 Агнуур зохион байгуулалт, менежментийн төлөвлөгөө

1. Хэнтий аймгийн Батширээт суманд шувууны нарийвчилсан агнуур зохион байгуулалт явуулах, агнуурын бүс нутгуудын менежментийн төлөвлөгөөг боловсруулах ажлын БО/2018/06 тоот гэрээг/Байгаль хамгаалах зардлаар 5 сая.төгрөг/ мэргэжлийн байгууллага болох Эко-Үйлчилгээ ТББайгууллагатай байгуулсан. Батширээт суманд Хавтгар, Ононгийн арал шувуу агнуурын бүсүүдэд нарийвчилсан агнуур зохион байгуулалтыг явуулан, менежментийн төлөвлөгөөг боловсруулсан. Батширээт сумын 2018.11.16-ны өдрийн ИТХ-н 23-р тогтоолоор агнуурын бүсийн хилийн цэсийг баталгаажуулан, 24-р тогтоолоор менежментийн төлөвлөгөөг дэмжсэн.

2. Онон голын агнуурын бүсүүдэд менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх БО/2018/-01-05 гэрээг /Байгаль хамгаалах зардлаар 10 сая.төгрөг/ Онон голын загасчдын холбоо төрийн бус байгууллагатай байгуулсан.

Батширээт, Биндэр, Баян-Адрага, Норовлин, Дадал сумдын Онон голын агнуурын бүсүүдэд нийт загас барихыг зөвшөөрөх тэмдэг 18 ширхэг, ус хөрс бохирдуулахыг хориглох тэмдэг 7 ширхэг, загас барихыг хориглох тэмдэг 11 ширхэг, мэдээллийн самбар 21 ширхэг, хилийн багана 11 ширхгийг тус тус хийсэн.

Онон голын агнуурын бүсийн тэмдэгжүүлэлт /Зураг-29/



3. Цагаан зээрэнд гоц халдварт шүлхий өвчний тандан судалгаа хийх зорилгоор Мал эмнэлгийн газартай БО/2018/17 ажлын гэрээг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар байгуулсан. /Байгаль хамгаалах зардлаар 2 сая төгрөг/ Дархан, Баян-Овоо, Батноров, Норовлин, Баян-Адрага, Дадал сумдын 6 газраас 12 толгой цагаан зээрээс 12 цусны дээж, 30 цуллаг, 6 тунгалгийн булчирхайн дээж авч ажиллана.

**6.”Аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээ” гэсэн байгууллагын
стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр арга хэмжээ**



6.1 Хэнтий аймгийн аялал жуулчлалыг сурталчлах үйл ажиллагаа

Хэнтий аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан “Чингис хаан брэнд” дэд хөтөлбөр 2017 оны 2 сарын 9-ний өдрийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 17 дугаар тогтоолоор батлагдсан. 2018 оны төлөвлөгөөнд нийт 10 ажил тусгагдсан.

1. Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр:

1.1 Чингис хаан дэд хөтөлбөрийн төлөвлөгөөг боловсруулан аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргаар батлуулан ажиллаа.

1.2 Мянганы суут хүн Их Эзэн Чингис хааны өлгий нутаг аялал жуулчлалын зөвлөгөөнийг зохион байгуулах

Хэнтий аймаг нь Монгол улсын түүхэн аялал жуулчлалын тулгуур бүс нутаг болон хөгжиж байгаатай холбогдуулан Чингис хотод аялал жуулчлалын салбарын зөвлөгөөнийг “Хэнтий аймгийн Аялал жуулчлалын хөгжил” нэртэйгээр зохион байгууллаа.

Аялал жуулчлалын салбарын зөвлөгөөн /Зураг-30/



“Мянганы суут хүн их Эзэн Чингис хааны өлгий нутагт тавтай морил” уриан дор аймгийн Засаг даргын тамгын газар, Улаанбаатар хот дахь Нутгийн зөвлөл, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Аялал жуулчлалын боловсрол хөгжлийн нийгэмлэг хамтран зохион байгуулсан бөгөөд аймгийн удирдлагууд Хэнтий аймгаас сонгогдсон УИХ-ын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Л.Оюун-Эрдэнэ, Д.Гантулга, нутгийн зөвлөлийн гүйцэтгэх захирал М.Батбаяр, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын дарга С.Бат-Эрдэнэ, Монголын Зочид буудлуудын холбооны гүйцэтгэх захирал Н.Батцэнгэл, Шинжлэх ухааны академийн түүх археологийн хүрээлэнгийн доктор Б.Цогтбаатар, Аялал жуулчлалын боловсрол хөгжлийн нийгэмлэгийн эрдэмтэн багш судлаачид, Хэнтий аймагт үйл ажиллагаа явуулдаг жуулчны баазуудын захирал, Зочид буудлын захирал менежер, хувиараа бизнес эрхлэгч, Дадал сумын Онон Балжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дарга мэргэжилтэн нар оролцлоо.

Аялал жуулчлалын салбарын зөвлөгөөн /Зураг-31/



Зөвлөгөөнд УИХ-ын гишүүн Л.Оюун-Эрдэнэ “Мянганы суут хүн их Эзэн Чингис хаан түүхэн аялал жуулчлалын үндэсний парк” төслийг танилцуулсан юм. Мөн Хэнтий аймгийн аялал жуулчлалын өнөөгийн байдал цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ, тулгамдаж буй асуудлын талаар илтгэгчид хэлэлцүүлж оролцогчид өөр өөрийн байр сууриа илэрхийлэн санал бодлоо солилцон ярилцсан бөгөөд аймгийн Засаг дарга Н.Ганбямба орон нутагтаа аялал жуулчлалыг хөгжүүлэхэд төсвийн хөрөнгө оруулалтын 20-30 хүртэлх хувийг зарцуулна гэдгээ илэрхийллээ. Зөвлөгөөний төгсгөлд Хэнтий аймагт аялал жуулчлалыг хөгжүүлэх түр хороог 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Б.Дархантөрөөр ахлуулахаар шийдвэрлэсэн бөгөөд төр хувийн хэвшлийн төлөөллүүд оролцсон энэхүү түр хороо цаашдаа хуралдаж төлөвлөгөө гарган асуудлуудаа нарийвчлан шийдвэрлэхээр болсноор зөвлөгөөн өндөрлөсөн юм.

1.2 Аялал жуулчлалын олон улсын үзэсгэлэнд оролцох ИТМ-д оролцох

Хэнтий аймаг нь 2009 оноос эхлэн ИТМ –аялал жуулчлалын үзэсгэлэнд аймаг орон нутгаа сурталчлан оролцсон бөгөөд сүүлийн 2 жилийн тоон үзүүлэлтийг авч үзвэл :

ИТМ -2016 аялал жуулчлалын олон улсын үзэсгэлэнд Хэнтий аймгаа төлөөлөн 5 жуулчны бааз оролцсон 1 жуулчны бааз 5-10 тур оператортой хамтран ажиллах жуулчин хүлээн авах гэрээ байгуулсан бөгөөд нийт 35 тур оператортой гэрээ байгуулсан ажилласан. Энэхүү гэрээний дагуу гадаадын жуулчин 1400, дотоодын жуулчин 15855 ирсэн байна.

ИТМ-2017 аялал жуулчлалын олон улсын үзэсгэлэнд 7 жуулчны бааз аймаг орон нутгаа өөрсдийн явуулдаг үйл ажиллагаатайгаа сурталчлан оролцсон. Үзэсгэлэнд оролцсоноороо давхардсан тоогоор нийт 50 тур операторуудтай гэрээ хийн ажиллалаа. Хэнтий аймагт урьдчилсан байдлаар гадаад дотоодын 10000 орчим жуулчид ирэх боломж нээгдсэн.

2017 онд Хэнтий аймагт дотоодын 30000 гаруй, гадаадын 2000 гаруй жуулчин ирсэн мэдээллийг холбогдох жуулчны баазуудаас аваад байна. 2016 онд ирсэн жуулчны судалгааг 2017 оны судалгаагаар

харьцуулвал гадаадын жуулчин 600 хүнээр буюу 42 хувь, дотоодын жуулчин 14145 хүнээр буюу 89,2 хувиар нэмэгдсэн байна. /График-4/

График-4



6.1.1 2018 оны “ ИТМ “ үзэсгэлэнгийн тухай:

Монголын аялал жуулчлалын холбооноос БОАЖЯ-тай хамтран жил бүрийн хавар уламжлал болгон зохион байгуулдаг “Ай Ти Эм-2018” үзэсгэлэнг 2018 оны 3 дугаар сарын 30-наас 4 сарын 1-ний өдрүүдэд 19 дэх жилдээ Улаанбаатар хотноо Мишээл Экспогийн шинэ үзэсгэлэнгийн танхимд зохион байгуулагдлаа.

Тус үзэсгэлэн нь Монголын хамгийн том аялал жуулчлалын үзэсгэлэн төдийгүй, 21 аймаг, 300 гаруй аж ахуй нэгжийн төлөөлөл хүрэлцэн ирж аймаг орон нутгийнхаа бүтээгдэхүүн, эвент арга хэмжээгээ сурталчлан танилцуулдагаас гадна аялал жуулчлалын бизнес эрхлэгчид шинэ бүтээгдэхүүнээ сурталчлах, борлуулах, түншлэлийн гэрээ хэлэлцээр хийх, гадаад, дотоодын аялал жуулчлалын салбарын судлаачдын семинарт оролцох зэрэг боломжоор хангагддаг билээ.

Хэнтий аймгийн хувьд 2009 оноос хойш 10 дахь жилдээ энэхүү үзэсгэлэнд оролцож байна. Үзэсгэлэнд оролцсоноор өөрийн аймгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүнүүдийг олон нийтэд сурталчилан танилцуулж, жилээс жилд туршлагжин талбай, зохион байгуулалт, тохижилт, үйл ажиллагаагаа өргөжүүлсээр ирсэн болно.

“ ИТМ “ үзэсгэлэн /Зураг-32/



Зохион байгуулалт:

Ай Ти Эм олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Батширээт сумаас -3 / Чингисийн өлгий, ДМД, Талын өргөө /, Биндэр-1 / Чингисийн тоонот, Дадал-1 / Чингисийн гурван нуур /, Дэлгэрхаан сумаас – 2 / Хүннү хөдөө арал, Хилчин амралтын газар, зэрэг нийт 4 сумын 7 жуулчны баазууд оролцож нийт 72 тур оператортой хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласан байна. Мөн үзэсгэлэнгийн үеэр Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимд Монголын зочид буудлын "Noreca expo" буюу зочид буудал, зоогийн газрын хангамжийн үзэсгэлэн зохион байгуулагдаж аймаг орон нутгаа төлөөлөн Хан бүргэд зочид буудал амжилттай оролцоо.

“ ИТМ “ үзэсгэлэн /Зураг-33/



18 м2 талбайг түрээслэн авч ШУА-ын Түүх, археологийн хүрээлэнгийн тэргүүлэх зэргийн эрдэмтэн доктор Б.Цогтбаатар, эрдэм шинжилгээний ажилтан доктор Н.Эрдэнэ-Очир нарын хамтран хийсэн Хэнтий аймгийн аялалын ерөнхий маршрутыг хэвлүүлэн, арын хана болох 6м ханыг бүтэн LED дэлгэцээр тохижуулж аймаг орон нутгийн сурталчилгаа болон түүх соёлын дурсгал, жуулчны баазуудын танилцуулга шторуудыг гаргаж үзэсгэлэн үзэж байгаа зочид төлөөлөгчидөд үзэж сонирхуулсан. Хэнтий аймгийн байгалийн үзэсгэлэнт газар, түүх, соёлын дурсгалт газрын танилцуулгыг англи хэл дээр хөрвүүлэн жуулчны баазуудын танилцуулгыг багтаасан сэтгүүлийг 1500 ширхэгийг хэвлүүлэн гаргаж олон нийтэд тарааж танилцуулсан.

Үзэсгэлэнгийн үеэр Дадал сумын гар урчуудын бүтээлүүдийн худалдаа явагдсан.

“ ИТМ “ үзэсгэлэн /Зураг-34/




Үр дүн:

Үзэсгэлэнд оролцсоноороо давхардсан тоогоор нийт 72 тур операторуудтай гэрээ хийн ажиллалаа. Хэнтий аймагт урьдчилсан байдлаар 5000 орчим жуулчид ирэх боломж нээгдсэн. Жилээс жилд өргөн хүрээтэй оролцож илүү туршлагажан ажиллаж байна. Тогорууны баяр, Ёохор, Талын түмэн адууны баяр, гэх мэт үйл ажиллагаа сурталчилагдсан. Хөрш орнууд, бусад аймгуудаас харилцан туршлага солилцох, бизнесийн шинэ түнштэй болох, гадаадад жуулчин илгээгч компаниудын шинэ бүтээгдэхүүний сурталчилагаа, аяллын хөтөлбөртэй танилцах, жуулчны байр сууцны үйлчилгээ эрхлэгчдийн энэ зуны үнийг хөнгөлттэй үнээр авах, аялал жуулчлалын бизнесийн эрх зүй, олон улсын стандарт, шинэ чиг хандлагын талаар гадаад дотоодын судлаачдын лекцэнд хамрагдах зэрэг боломжоор хангагдлаа.

6.1.2 ӨМӨЗО Хөх хотод зохион байгуулагдсан үзэсгэлэнд оролцлоо

ӨМӨЗО-ны Хөх хотод зохион байгуулагдсан Аялал жуулчлалын үзэсгэлэнд Хэнтий аймагт үйл ажиллагаа явуулдаг 6 жуулчны бааз, 2 зочид буудал амжилттай оролцлоо. Үзэсгэлэнгийн үеэр Хөх хотын аялал жуулчлалын тур операторуудтай уулзалт хийж Их Эзэн Чингис хааны өлгий нутаг Хан Хэнтий нутгаа сурталчилан цаашид хамтран ажиллахаар боллоо.

Аялал жуулчлалын үзэсгэлэн /Зураг-35/



6.1.3 “Улаанбаатар травэл экспо 2018” аялал жуулчлалын үзэсгэлэн

"Улаанбаатар Травэл Экспо 2018" аялал жуулчлалын үзэсгэлэн Үндэсний Цэцэрлэгт Хүрээлэнд 2018 оны 6 сарын 2-3-ний өдрүүдэд 2 өдрийн турш амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Үзэсгэлэнд Хэнтий аймгаа төлөөлөн Чингисийн гурван нуур, Биндэр суманд үйл ажиллагаа явуулдаг Чингисийн тоонот

жуулчны баазууд, Эзэнт гүрэн ресторан амжилттай оролцож нийт 1000 орчим танилцуулга брошур, тарааж 10 гаруй аж ахуй нэгжтэй хамтран ажиллах гэрээ байгууллаа.

“Улаанбаатар травэл экспо 2018” аялал жуулчлалын үзэсгэлэн/Зураг-36/




Аялал жуулчлалын үзэсгэлэнг БОАЖЯ, НАЖГ хамтран зохион байгуулсан бөгөөд Түнш аймгаар Ховд аймаг, ерөнхий спонсор Мобиком корпораци, мэдээллийг дэмжиж ажилласан.

Энэхүү үзэсгэлэнд Элчин сайдын яамдууд, Тайванийн Төлөөлөгчийн газар, ӨМӨЗО болон өөрсдийн үйл ажиллагаагаа идэвхитэй танилцуулан олон сонирхолтой үйл ажиллагаа зохион явуулсан U Travel, Хөгжилтэй аялал, United Express, CISV Mongolia, Amazing Travel, Great sea resort зэрэг нийт 90 гаруй байгууллага 6 аймгийн төлөөлөл оролцлоо.

Үзэсгэлэнгийн үеэр олон сонирхолтой илтгэл тавигдлаа. Энэ жилийн үзэсгэлэнгийн үеэр "Улаанбаатар Травэл Кап 2018" хөл бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулагдсан нь урьд урьдны жилүүдээс онцгой байлаа.

“Улаанбаатар травэл экспо 2018” аялал жуулчлалын үзэсгэлэн /Зураг-37/



6.1.4 НИТАЖ-ын сургалт

Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Аялал жуулчлалын ур чадварын мэргэжлийн сургууль, Мөнх-Харилцаа төрийн бус байгууллагатай хамтран “Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын боловсрол олгох” сургалтыг Хэнтий аймгийн Биндэр суманд 2018 оны 07 дугаар сарын 21 -ны өдөр Сумын ЗДТГ-ын Иргэний танхимд ойролцоох сумдын орон нутгийн иргэдэд зохион байгууллаа.

Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын сургалт /Зураг-38/



Уг сургалтын зорилго: Аялал жуулчлалын салбарын хөгжлийн чиг хандлага, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх зарчим, байгалийн нөөц, түүх, соёлын өвийг экологийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон ашиглах, аялагч жуулчдад үйлчлэх, тайлбар хийх хөтөчийг бэлтгэх, байгаль хамгаалах тухай шинэлэг арга туршлага, ур чадварыг эзэмшүүлэх, Орон нутгийн иргэдийн аялал жуулчлалаас хүртэх үр ашиг, иргэдийн амьжиргааны эх үүсвэрийг нэмэгдүүлэх, нутгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжлийг дэмжих, салбарын сүүлийн үеийн мэдээ мэдээллийг тус орон нутгийн нөхөрлөлийн гишүүд, өрхийн аж ахуй эрхлэгчдэд хүргэх, *᠔᠗᠔᠙᠐᠗᠎ᠠ ᠠᠨᠠᠭ᠎ᠠ* *ᠠᠨᠠᠭ᠎ᠠ* *ᠠᠨᠠᠭ᠎ᠠ*, нэгдсэн ойлголт мэдээлэлтэй болгох зорилготой байсан. Сургалт зохион байгуулахад урьдчилан баталсан хөтөлбөр төлөвлөгөөнд заасан агуулга, орох цагийн дагуу амжилттай явуулж зорилгоо бүрэн биелүүлсэн болно.

Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын сургалт /Зураг-39/



Сургалтанд оролцогчдыг эхний ээлжинд Know буюу мэдэх зүйлс, Want буюу мэдэхийг хүссэн зүйлсийг бичүүлэн түүндээ анализ хийн хамтран ажиллаж харилцан суралцах, бусдынхаа санал бодлыг сонсон дэмжих, харилцан мэтгэлцэх, харилцан мэдээлэл өгөх, зөв шийдэлд хүрэх зэрэг аргуудыг хэрэглэн эцэст нь Learning буюу Мэдэж сурсан зүйлсийг тэмдэглэн ялган харуулж сургалтыг явц, үр дүнг нээлттэй явуулж амжилттай зохион байгуулсан. Сургалтанд Биндэр, Бат ширээт сумын ЗДТГ-н мэргэжилтэнгүүд, оролцогч Нөхөрлөлүүдээс Цагаан нуга, Дэлгэрэх онон, Уран сүлжээ, Иргэн Одгэрэл, Нацагдорж зэрэг хүмүүс идэвхтэй оролцсон болно.

6.1.5 Үйлчилгээний ажилтнуудыг чадавхжуулах, үйлчилгээний технологи сургалт

Монгол Улсын Засгийн газраас эзэн Чингис хааны төрсөн нутаг Хэнтий аймгийг түүхэн аялал жуулчлалын бүс нутаг болгон зарласан. Аймаг орон нутгаас барьж буй бодлого ч мөн адил аялал жуулчлалыг хөгжүүлэх аж ахуй нэгж, иргэдийнхээ орлогыг нэмэгдүүлэх байр суурьтай байдаг. Тиймээс жуулчдыг татах зорилгоор Батноров суманд Андлалын өргөө, Биндэр суманд Их Монгол цогцолбор, Дадал суманд Мянганы суут хүн их эзэн Чингис хаан цогцолборуудыг эхлүүлээд байна. Үүний зэрэгцээ үйлчилгээний байгууллагуудын чанар стандартыг сайжруулах, хүний нөөцийг чадавхжуулах нь чухал юм.

Энэ утгаараа 2018 оны 10 сарын 23-24 өдрүүдэд Аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Хэнтий аймаг дахь худалдаа аж үйлдвэрийн танхим хамтран Хэнтий аймгийн зочлох үйлчилгээний салбарын ажилтнуудад зориулсан Үйлчилгээний ажилтнуудыг чадавхжуулах, үйлчилгээний технологи “сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

Үйлчилгээний технологи сургалт /Зураг-40/



Сургалтын нээлтэд аймгийн Засаг даргын орлогч Ц.Чогсомжав, Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Э.Мөнх-Эрдэнэ нар оролцсон бөгөөд аймгийн төвийн зочид буудал, жуулчны баазын төлөөлөлүүд хамрагдлаа. Сургалтыг Монголын зочид буудлуудын холбооны мэргэшсэн зөвлөх Н.Батцэнгэл, Менежер Б.Өнөрбаяр нар уудирдан явуулсан бөгөөд үйлчилгээний салбарын мэргэжлийн ёс зүй, харилцааны ур чадвар, хүний нөөцийн бүрдүүлэлт, төлөвлөлт, ширээ засалтын техник

ажиллагаа арга зүй зочдыг угтах, үдэх өрөөний цэвэрлэгээ, угаалга зэрэг үйлчилгээг хэрхэн үзүүлэх талаар онол практикийн сургалтыг зохион байгууллаа. Сургалтанд хамрагдсан үйлчилгээний ажилтнуудад аймгийн Засаг дарга Н.Ганбямба цаашдын ажилд нь амжилт хүсэж сертификат гардууллаа.

Үйлчилгээний технологи сургалт /Зураг-41/



6.2 Аялал жуулчлалын эвент арга хэмжээнүүд

6.2.1 Тогорууны баяр

Тогорууны баярын арга хэмжээг Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь Хөтөлбөрийн газар, ШУАкадемийн Ерөнхий ба Сорилын биологийн Хүрээлэн, Зэрлэг амьтан судлах хамгаалах төв, Олон улсын тогорууны сан, Монгол хан экспедиц, Хан Хэнтийн УТХГ-ын хамгаалалтын захиргаа, Онон-Балжийн БЦГ-ын Хамгаалалтын захиргаа Geograffice Expedition зэрэг байгууллагуудтай хамтран 2013 оны 06 сарын 13-ний өдрөөс эхлэн Тогорууны фестивалийг Монгол наадмын хүрээнд зохион байгуулсаар өдгөө 5 дэх жилдээ амжилттай зохион байгуулагдлаа.

Тогорууны баяр /Зураг-42/



Монгол орон маань дэлхийд ховордсон гайхалтай үзэсгэлэнт 6 зүйл тогоруу шувууны өсч үржиж байгаа сүүлийн Баянбүрд бөгөөд тэдгээрийг харж ажиглах, хамгаалах цөөхөн газрын нэг нь Хурх-Хүйтний хөндий учраас үр хүүхдүүддээ өвлүүлэн үлдээх, цаашилбал харж хамгаалах, өсөж үржихэд нь

анхаарал хандуулах шаардлагатай юм. Тийм ч учраас Монгол оронд төдийгүй дэлхийн хэмжээнд ховордож байгаа цэн тогоруу, өвөгт тогоруу, цагаан тогоруу, хар тогоруу, хархираа тогоруу, алаг тогорууд, ус намгархаг газрын хамгааллын тухай нутгийн иргэдийн ойлголтыг сайжруулах, олон нийтэд сурталчлах, төрөлх нутгийнхаа байгалийн баялагаар бахархах сэтгэлийг дэмжин хөгжүүлэх, цаашлаад Монгол улсаа дэлхийд сурталчлах, олон улсын чанартай фестиваль болгох зорилгоор уг наадмыг зохион байгуулдаг билээ.

Уг үйл ажиллагаанд гадаадын 56 жуулчин, дотоодын 500 гаруй жуулчид зорин ирж оролцсон юм.

Хөтөлбөрийн дагуу эрийн гурван наадам, шагайн харваа, саадтай морин уралдаан, хос морьтон, эссэ бичлэг зэрэг тэмцээн уралдаанууд, Биндэр, Дадал, Норовлин, Хурх зэрэг сумдаас Тогорууны тухай бүжгийн үзүүлбэрүүд, Буриад дуу бүжгийн тоглолт, галын наадам гээд олон олон үйл ажиллагаанууд зохион байгуулагдлаа.

6.2.2 Галшар адууны баяр

Аймгийн Засаг даргын ивээл дор жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “ГАЛШАР АДУУНЫ БАЯР – 2018 ” аялал жуулчлалын эвент арга хэмжээ Галшар адууг үндэслэгч Их шинжээч, төр нийгмийн зүтгэлтэн Хардэл жанжин бэйс М.Пүрэвжавын хурдан хүлэг морьдоо уяж сойдог байсан Галшар сумын Шөрмөсөн чулуут дов хэмээх газарт 07 сарын 25-26 -ны өдөр зохион байгуулагдлаа. Монгол улсад адууны анхны үүлдэрээр Галшар адуугаа баталгаажуулж Галшар сум “Хоёр түмэн адуу”-тай болсон зэрэг үйл явдлуудыг хамтад нь тэмдэглэн өнгөрүүлээ.

Галшар адууны баяр /Зураг-43/



Хэнтий аймгийн Засаг дарга

Н.Ганбямба

Энэхүү Галшар адууны баярын гол нэгэн арга хэмжээ бол “Монгол хүү” наадам юм. Энэхүү наадамд хурдны моринд хүндэдсэн 15-16 насны хүүхдүүд оролцдог бөгөөд өөрсдөө морь унаж уралдах, бөх барилдах, сур харваж хоорондоо өрсөлддөг нь олны анхаарлыг ихэд татдаг арга хэмжээний нэг болдог. Энэхүү арга хэмжээнд Сүхбаатар, Дорноговь аймгуудаас гадна сумдын төлөөллүүд болох нийт 500 гаруй хүн оролцсон арга хэмжээ боллоо.

Галшар адууны баяр /Зураг-44/



6.2.3 Монгол Тайга нохойн наадам

“Монгол Тайга Нохойн Наадам” –“ХЭНТИЙ 2018” эвент арга хэмжээ 8-р сарын 10 нд Баянхутаг сумын нутагт зохион байгуулагдсан бөгөөд арга хэмжээнд аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Э.Мөнх-Эрдэнэ, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Б.Дархантөр, Монгол тайга нохойн Хэнтий аймаг дахь салбарын тэргүүн Ч.Бат-Эрдэнэ нар оролцлоо. Уг арга хэмжээг аймгийн Засаг дарга 1 сая төгрөгний дэмжлэг үзүүллээ.

Монгол Тайга нохойн наадам /Зураг-45/



Монгол Тайга нохойн арга хэмжээ нь урд онтой харьцуулахад оролцогчид Анч Тайга нохойгоон үзэсгэлэн болон уралдаан тэмцээнд маш сайн бэлдэж ирсэн буюу нийт **80 Анч Тайга** нохой хүрэлцэн ирж нас насны ангилалаар өрсөлдсөн, **ТАЛЫН ГӨРӨӨЧИН** шалгаруулах төрөлд **унаа морь**, уламжлалт **дээл хувцас** **ангийн салаа хөтөлгөө** гэх мэт зүйлүүдээ бэлтгэн ирж идэвхитэй оролцож байгааг хархад цаашид энэ наадмыг зорин ирэх оролцогч болон үзэгчдийн тоо 200 аад хүн байсан нь цаашид ч өсөхөөр байгааг харуулж байна. Мөн дашрамд дурьдхад дотоодын 2 ч тур оператор компаниас жуулчин авчрах хүсэлтэй байсан ч хийх боловсруулах зүйл байсан тул гадны жуулчин авахаас энэ удаа татгалзсан юм.

6.2.4 Талын түмэн адуу


Талын түмэн адуу -2018 эвент арга хэмжээг 2018 оны 11 дүгээр сарын 2-4-ний өдрүүдэд Батноров суманд зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээг [Байгаль орчин, аялал жуулчлалын яам](#), Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл Урлагийн газар, Хэнтий аймгийн ЗДТГ, Хөдөө аж ахуйн газар, БОАЖГазар, Сэцэн ханы ордон музей, Хан Хэнтий чуулга, Батноров сумын ЗДТГ, [Нийслэлийн Аялал Жуулчлалын Газар](#), Эргэх Холбоо ТББ, УИХ-ын гишүүн Л.Оюун-Эрдэний ажлын алба, Монгол төрийн дархан нэгдсэн холбоо, Батноров сумын Улаанбаатар хот дахь Нутгийн Зөвлөл, Монгол Тайга Холбоо, Гэрэл зурагчдын нэгдсэн холбоо гэх мэт олон өөр байгууллагууд нэг зүйлийн доор нэгдэж амжилттай зохион байгуулсан бөгөөд арга хэмжээнд 3 өдрийн хугацаанд 2000 орчим гадаад, дотоодын хүнийг цуглуулж, 15 орноос жуулчин татсан эвент боллоо. *Талын түмэн адуу /Зураг-46/*



Аймаг орон нутгийн зүгээс Талын түмэн адуу арга хэмжээ зохион байгуулагдахтай холбоотойгоор 2 удаа комисс хуралдсан. Хуралдааныг аймгийн Засаг даргын орлогч Ц.Чогсомжав удирдан явуулсан. Энэхүү комисст Цагдаа, Эрүүл мэндийн газар, Хан Хэнтий чуулга, Музей, Нийтлэг үйлчилгээний газар оролцож өөр өөрсдийн ажлыг хариуцан авсан юм. Аймаг орон нутгийн зүгээс 2 сая төгрөгний дэмжлэг үзүүлэн дэмжиж ажиллаа. *Талын түмэн адуу арга хэмжээний ажлын хэсэг /Зураг-47/*



7. "Хот суурин газрын орчны бохирдлын хэмжээг бууруулах арга хэмжээ" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ




7.1. Агаар, хөрс, усыг бохирдуулж байгаа эх үүсвэр, хаягдлын тооллого явуулж, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлж, хяналт шинжилгээг үр дүнтэй болгох

Менежментийн төлөвлөгөөг боловсруулах зорилгоор Чингис хотын агаарын бохирдлын судалгааг Грейн ази консалтинг ХХК-тай гэрээ байгуулан ажилласан. Ажлыг хүлээн авсан.

Хүхэрлэг хийн болон азотын давхар ислийн 24 цагийн дундаж агууламж, загварчлалын үр дүнгээр агаарын “хэвийн” гэсэн үнэлгээтэй байна.

Агаарын бохирдолын судалгаа /Зураг-48/




Судалгаагаар Чингис хотын агаарын чанарын индексийн үнэлгээгээр хэмжилтийн ихэнх цэгүүд дээр агаарын чанар “Бага зэргийн бохирдолтой” гэсэн үнэлгээ авсан. Энэ хугацаанд агаарын чанар байршлаас хамааран харилцан адилгүй байсан байна. Ялангуяа PM10 тоосонцрын агууламж гэр хорооллын бүсэд харьцангуй их байлаа. Агаарын бохирдол хамгийн их байх хоногийн мөчлөг нь байршлаас хамааран өөр өөр байсан ч ерөнхийдөө айл өрхийн галлагааны циклтэй давхцан өглөөний 07-09 цаг, үдшийн 18-24 цагийн хооронд бохирдол ихтэй гэж гарч байна.

7.2. Хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах, аюултай хог хаягдлын менежментийг зохицуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох, аюултай хог хаягдлыг байгаль орчинд халгүй аргаар устгах

"Хэнтий аймгийн ногоон хөгжилд суурилсан тогтвортой хөгжлийн хэтийн зорилт 2026" -ын хүрээнд хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор аймгийн ЗДТГ, олон нийтийн мэдээллийн "Хэнтий мэдээ агентлаг"-тай хамтран "Бид Бүтээгчид" гэсэн бүтээлч уралдаан зарлан ажилласан. Бүтээлийг 10 сар хүртэлх хугацаагаар хүлээн авч шалгаруулахад Биндэр сумын иргэн Нацагдорж нь гар аргаар хуванцар сав шахаж хайлуулан, явган хүний замын хавтан хийж тэргүүлсэн.

Бид бүтээгчид уралдаан /Зураг-49/



Батноров сумын Бэрх тосгоны хог хаягдлын цэгт хуримтлагдсан хогийг түрж булах ажлыг гүйцэтгэсэн. 10га талбайн хог хаягдлыг 200м урт шуудуунд хогийг түрж булснаар хөрсөн дээрх хог хаягдлын талбайн хэмжээг 50орчим хуваарь бууруулсан.

Хуримтлагдсан хогийг түрж булав /Зураг-50/



7.3. Нүхэн жорлон, угаадасны нүх техникийн шаардлага MNS 5924:2015 стандартыг хэрэгжүүлэх, шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх

Хэрлэн сумын ЗДТГазраас Дэлхийн зөн ОУБ-ын Бор-Өндөр 2 төсөлтэй хамтран аймгийн "Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил"-ийн хүрээнд Залуу гэр бүлийг дэмжих зорилгоор 14 залуу өрхөд газар олгож, байшинг хөнгөлөлттэй үнээр барьж, нүхэн жорлонгийн асуудлыг нь шийдвэрлэхээр ажил хийгдсэн.

Аймгийн хэмжээнд хөрсний бохирдлын судалгааг Грейн Ази Консалтинг мэргэжлийн байгууллагаар 23 сум, сууринд хийлгэж, нийтдээ 122 цэгээс дээж авч шинжилгээ хийгдсэн. Хүхэрлэг хийн болон азотын давхар ислийн 24 цагийн дундаж агууламж, загварчлалын үр дүнгээр агаарын "хэвийн" гэсэн үнэлгээтэй гарсан.

8. "Байгаль орчны чиглэлийн сургалт сурталчилгаа, хяналт шалгалт, мэдээллийн санг баяжуулах" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ



8.1 Байгаль орчны чиглэлийн сургалт сурталчилгаа

Уул уурхайн чиглэлээр:

Хэнтий хаймгийн Засаг даргын Тамгийн газар, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газартай хамтран 2018 оны 06 дугаар сарын 13-ны өдөр “Уул уурхайн шийдвэр гаргалтанд талуудын оролцоог хангах хамтын ажиллагааны тогтолцоо” сэдэвт хэлэлцүүлгийг Хэнтий аймгийн Чингис хотод зохион байгууллаа. Зөвлөгөөн Хэнтий аймгийн 18 сумын Засаг дарга, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, Холбогдох төрийн байгууллагийн төлөөлөл, аймгийн удирдалгууд, аж ахуй нэгжийн төлөөлөл хийт 106 орчим оролцогч оролцлоо.

Хариуцлага ба хамтын ажиллагаа зөвлөгөөн /Зураг-51/



Амьтны чиглэлээр:

1. 2018.05.16-ны өдөр Чингис хотод “Чингисийн шонхорууд” нэг жилийн хугацаанд хэрэгжих шувуу хамгаалах, сурталчлах, танин мэдүүлэх аяныг Хэрлэний домог ТББ, Шувуу хамгаалах төв нь аймгийн БОАЖГазар, Хэрлэн голын сав газрын хамгаалалтын захиргаа, Хэрлэн 1-р сургууль хамтран эхлүүлсэн.

Чингисийн шонхорууд аяны нээлт /Зураг-52/



2.2018.03.02-ны өдөр Биндэр суманд БОАЖГазар нь аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран Онон голын сав газарт “Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, түүний илрүүлэлтийг сайжруулах нь” сэдэвт уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулсан.


Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зөвлөгөөн /Зураг-53/



3.2018.03.15-16-ний өдрүүдэд Улаанбаатар хотод “Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөөг боловсруулах сургалт”-нд биологийн төрөл зүйл, тусгай хамгаалалттай газар нутаг хариуцсан мэргэжилтнүүд оролцлоо.

4. 2018.09.14-ний өдөр Улаанбаатар хотод “Биосан” арга зүйн нарийвчилсан сургалтыг Ерөнхий болон Сорилын Биологийн хүрээлэн болон Ой бүхий аймгуудын биологийн олон янз байдлын хамгаалал, ойн тогтвортой менежмент, нүүрстөрөгчийн хуримтлалыг нэмэгдүүлэх төсөл хамтран зохион байгуулсан. Энэхүү сургалтанд Хэнтий, Булган, Дархан, Хөвсгөл, Сэлэнгэ аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын биологийн төрөл зүйл хариуцсан мэргэжилтнүүд “хамрагдсан.

Биосангийн сургалт/ Зураг-54/



Харгалттай арга	Нэр	Харгалттай арга	Төрөл	Харгалттай арга
1	ТТТ	Салдур	Хүний	Хүний
2	Мүнхлэнцүүл	Мөнхлүүр	Бадан	Хүний
3	Булган	Энх	Энх	Хүний
4	Хөвсгөл	Булган	Төмөр	Хүний

Ойн чиглэлээр:

1. Ой хээрийн түймэртэй тэмцэх арга зүйн сургалт:

Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Онцгой байдлын газар, НҮБ-ын ХХААБ-ын “Ой бүхий аймгуудын биологийн олон янз байдлын хамгаалал, тогтвортой ойн менежмент, нүүрстөрөгчийн хуримтлалыг нэмэгдүүлэн нь” төсөл зэрэг байгууллагууд хамтран “Ойн хээрийн түймэртэй тэмцэх арга зүй” сэдэвт сургалтыг 2018 оны 4,10 дугаар саруудад бүсчилэн ой бүхий 8 сумдад зохион байгуулсан.

Сургалтыг Хэнтий аймгийн Онцгой байдлын газрын ахлах дэслэгч Х.Эрдэнэбат, ахлах ахлагч Ц.Төмөрбаатар, БОАЖГ-н Ойн албаны мэргэжилтэн Э.Батсайхан нарын бүрэлдэхүүнтэйгээр ой бүхий 8 сумын ЗДТГ, сумдын ойн нөхөрлөлийн холбоо, ойн нөхөрлөлийн 220 гишүүд, Цэнхэрмандал, Өмнөдэлгэр сумдын сайн дурын 20 гишүүдийг хамруулсан нийт 260 оролцогчдод Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх багаж тоног төхөөрөмжийг танилцуулах, ой хээрийн түймэртэй тэмцэх арга ажиллагаанд сургах, эмнэлэгийн анхан шатны тусламжийг үзүүлэх, арга зүйд сургах, дадлага ажил зэрэг арга зүйд сургасан сургалтыг зохион байгуулсан. Сургалтаар:

- Ой хээрийн түймрийн үед ажиллах дараалал, ой хээрийн түймэртэй тэмцэх багаж тоног төхөөрөмж, ажлуулахад анхаарах зүйлс,
- Эмнэлэгийн анхан шатны тусламж үзүүлэх, түүний арга зүй, ой хээрийн түймэр гарч буй нөхцөл шалтгаан,
- Ой хээрийн түймэртэй тэмцэхэд орон нутгаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ
- Төслийн 2018 онд зохион байгуулсан ажлын тайлан, 2019 онд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг танилцуулсан.
- Дадлага ажил /Бага хэмжээний газарт зориудаар шатааж үлээгч аппарат болон бусад багаж тоног төхөөрөмжөөр унтраах үйл ажиллагааг дадлага ажлаар заасан/

Ой хээрийн түймэртэй тэмцэх сургалт /Зураг-55/



8.2 Байгаль орчны хяналт шалгалт арга хэмжээний хүрээнд

Амьтаны чиглэлээр:

1. Баян-Адарга сумын БОХУБ, байгаль хамгаалагчид, хэсгийн төлөөлөгч, Онон голын загасчдын клубын гишүүд хамтран хууль бус ан агнууртай тэмцэх эргүүл шалгалтын хүрээнд загас, бор гөрөөс, зээр гэх зэрэг амьтдад эргүүл шалгалтыг 4-5 сард, 7-10 сард нийт 4 удаагийн давтамжтайгаар хийсэн. Хяналт шалгалтын хүрээнд нийт 15 зөрчил гаргасан иргэний галт зэвсгийг хурааж цагдаагийн байгууллагад шилжүүлсэн. 57 ширхэг хавхыг хураан устгалд оруулсан. 1,6 сая төгрөг

2. Жаргалтхаан сумын БОХУБ, байгаль хамгаалагчид 300 ш брошур тарааж, 9 тарвага агнасан зөрчил илрүүлсэн. 2,7 сая төгрөг зарцуулсан.

3. Жаргалтхаан суманд 9 толгой, Дэлгэрхаан суманд 8 толгой, Батноров суманд 6 толгой буюу нийт 23 толгой тарвага агнасан зөрчил илрүүлсэн.

Эргүүлийн зураг /Зураг-56/



4. Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан “Хэнтий аймгийн нутаг дэвсгэрт амьтны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, хууль бус агнуурийг бууруулах, хяналтыг сайжруулах удирдамжийн дагуу аймгийн Цагдаагийн газрын эдийн засгийн мөрдөгч Б.Намсрай, БОАЖГ-н жолооч Б.Соронзонболд, Батноров сумын БОХУБ Г.Ариунбаяр, тус сумын 3-р багийн дарга Б.Өсөхбаяр, 3-р багийн иргэдийн нийтийн хурлын дарга Ц.Сүхбаатар, байгаль хамгаалагч Б.Мөнхтөр, нарын бүрэлдэхүүнтэй Батноров, Норовлин сумдын нутгаар 2018 оны 08 дугаар сарын 14,15-ний өдрүүдэд ажилласан.

Батноров сумын иргэн Ж.Батчулууныг “Дэл улаан” нэртэй газар тарвага агнахаар тоз-8 маркийн буу, даллуур зэргийг биедээ авч явахад нь хураан авсан. Дэл улааны урд тал буюу “Улаан шовх” нэртэй газар Батноров сумын иргэн Д.Эрдэн очир нь хүргэн Д.Бат-Эрдэнэ- ий хамт туламласан тарвага боож идэх гэж байхад нь барьж хураан авч тэмдэглэл үйлдсэн. Модтой дэл улааны зүүн доороос Норовлин сумын иргэн Ц.Бат-эрдэнэ, Б.Батжаргал, Ч.Эрдэнэбилэг нарыг 15 ширхэг хавх тавьж 5 тооны тарвага агнасан зөрчлийг илрүүлж тарвага болон хавхыг хураан авсан. Дараагийн өдөр Батноров сумаас баруун хойш Эхэнбүрд, Мянган модот, Норовхаан, Цагаан өндөр, Бор хоолойн даваа, Хавчиг даваа, Ихэр, Дэлгэрхаан, Хэлтгий, Цагаан чулуут, Дэлгэр булагын даваа гэсэн маршрутаар ажилласан. Энэ өдөр Батноров сумын Засаг даргын

орлогч Г.Отгонбаяр, 2-р багийн засаг дарга Г.Равзанаагийн нар нэмэгдэн очиж ажиллахад Батноров сумын иргэн Б.Болдбаатар байгалийн өнгөт чулуу ухаж байхтай таарч чулууг болон чулуу ухдаг багажийг нь хураан авсан. Нийт хяналт, шалгалтын явцад 16 иргэн, 4 авто машин, 6 мотоцикол шалгаж тос-8 маркын ангийн буу 2 ширхэг, хавх 25 ширхэг, 6 ширхэг тарвага хураан авсан. 25 ширхэг хавхыг Батноров сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч Г.Ариунбаярт хүлээлгэн өгсөн. Цагдаагийн газарт 6 ш тарвагыг хүлээлгэн өгсөн тэндээсээ ЗОНУЗ өвчин судлалын төвд хүргүүлэн хөндлөнгийн гэрч байлцуулж тарвагыг устгуулахаар тохиролцсон.

Шалгасан тээрвийн хэрэгсэлээс 1-2 ширхэг хавх болон бага хэмжээний өнгөт чулуу, мөн ухдаг багаж хэрэгсэлүүд нь хүртэл илэрсэн. Батноров сумын Шаварт нэртэй газар хууль бусаар Байгалийн өнгөт чулуу ухаж байсан 5 машин 12 иргэн иргэнийг шалгаж хараацай нэртэй багаж 7 ширхэгийг хураан авж тэнд байсан иргэдийг тараасан. 2 уут өнгөт чулуу хураан авсаныг шийдвэрлүүлэхээр Батноров сумын БОХУБ Г.Ариунбаярт хүлээлгэн өгсөн.

Хяналт шалгалт /Зураг-57/



Ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагааны чиглэлээр:

Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн нөхөн сэргээлт хийсэн байдалд 2 удаа тандалт судалгаа хийж гүйцэтгэсэн. Өнөөгийн байдлаар гарсан зөрчилгүй.

Он гарсаар Баян-Овоо сумын нутаг дэвсгэрт ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Ханшашир” ХХК дүйцүүлэх нөхөн сэргээлтээр 1.09 га, Айвуун тэс ХХК техникийн 5.9 га биологийн 2.9 га, Нутгийн мана ХХК 1.5 га, Шандын нуруу ХХК техникийн 4.2 га, биологийн 4,2 га талбайг аймгийн байгаль орчны нөхөн сэргээлт хүлээн авах комисст хүлээлгэн өгөөд байна

Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу 3 удаа, Засгийн газрын хамтарсан ажлын хэсэгтэй 1 удаа Батноров, Норовлин сумдын нутагт хууль бусаар байгалийн өнгөт чулуу олборлож байгаа иргэдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 55 кг өнгөт чулуу, газар ухах зориулалт бүхий багаж /хараацай гэх/ 37 ширхэг, лоом царил 11 ширхэг, хүрз 9 ширхэг, цахилгаан мотор 1ш, цахилгаан бутлагч 1 ширхэг хураан авч ажиллаа.

Уул уурхайн хяналт шалгалт /Зураг-58/



Ойн чиглэлээр:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 48 дугаар зарлиг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн “2018 ойгоос мод бэлтгэх дээд хязгаар батлах тухай” 08 дугаар тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавих, сум болон сум дундын ой ангийн 2018 онд олгосон ойгоос мод бэлтгэх эрхийн бичиг, мод модон материалын гарал үүслийн гэрчилгээний зарцуулалт, ойн нөхөрлөл ойн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор хяналт шалгалтын ажлыг 4, 11, 12 дугаар саруудад аймгийн БОАЖГ, Цагдаагийн газар, МХГ-ууд хамтран ой бүхий сумдад бүсчлэн зохион байгууллаа. Шалгалтаар Ойн тухай хууль зөрчсөн 2 иргэнийг илрүүлэн Цагдаагийн байгууллагад шилжүүлэн, мод бэлтгэлийн 5 ойн мэргэжлийн байгууллагад МХГ-аас торгууль ноогдуулсан.

Талбай дээр хяналт хийв /Зураг-59/



Ой бүхий сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, сум болон сум дундын ойн анги хамтран хууль бус мод бэлтгэлээс урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгаа хийх, хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх хяналт шалгалтын ажлыг 114 удаа зохион байгуулан, хууль бусаар мод бэлтгэсэн, ойгоос мод бэлтгэх эрхийн бичгийн нөхцөл болзол зөрчсөн 14 удаагийн зөрчил ирүүлэн торгууль шийтгэл ноогдуулсан байна.

Аялал жуулчлал, усны чиглэлээр:

Аймгийн Засаг даргын 2017 оны А/201 тоот захирамжаар батлагдсан ажлын хэсэг Дэлгэрхаан сумын Засаг даргын тамгын газрын Иргэний танхимд болсон “Тосон болон Бүрд нуурын усны түвшин багасаж байгаад тус сумын иргэдтэй уулзах зөвлөгөөнд оролцсон.

Тус ажлын хэсгийн ахлагчаар Ус, цаг уур орчны шинжилгээний газрын дарга Л.Чулуун явсан бөгөөд ажлын хэсгийн гишүүд иргэдэд нуурын орчмын бохирдлын болон хөрсний бохирдлын талаар мэдээлэл хүргэж, асуусан асуултанд хариуллаа.

Мөн Хэнтий-Ус ХХК-ны тоолуур хариуцсан инженер Ганболдыг сум орон нутгийн удирдлагуудтай уулзуулж, амралт үйлчилгээний зориулалтаар үйл ажиллагаа явуулж байгаа 10 иргэн, аж ахуйн нэгжид усны тоолуурыг суурилуулахад судалгаа хийлгэж, тоолуур тавих боломжтой газрын тоог авч ажилласан.

Иргэд, аж ахуйн нэгжтэй уулзав /Зураг-60/



Стандартын шаардлагад нийцсэн нүхэн жорлонг бариулах, шингэн хаягдлын цэгийг засаж, мал орохооргүй болгох зэрэг ажлыг хийх талаар сумын иргэд болон Засаг даргын орлогч Төгөлдөрт хэлж харилцан санал солилцлоо.

Мөн “голын орчимд тариалангийн зориулалтаар газар авч голын голдирлыг өөрчлөн хааж усалгаа хийж байна” гэсэн мэдээллийн дагуу тус суманд оршин суугч иргэн Аменбекийн газарт ажлын хэсгийнхэн сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагчтай хамт очиж газар дээр нь үзсэн. Ингэхэд Аваргын голын тохойноос суваг татан усалгаа хийж байсан. Тухайн иргэнд ажлын хэсгийнхэн заавар зөвлөмж өгсөн бөгөөд голоос шуудуугаар услах зөвшөөрөл авсан зэрэг бичиг баримт бүрдүүлэхийг зөвлөсөн

Аваргын голд хяналт хийж буй байдал /Зураг-61/



Монгол улсын Засгийн газрын байгаль орчинтой холбоотой гарсан тогтоол шийдвэр /Хүснэгт-1/

Шийдвэрийн дэс дугаар	Зүйл, заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Хэрэгжилтийн явц	Үнэлгэ э, /хүчин гүй болсон, хяналт аас хасуул ах тухай санал/	Тас арса н бол он удаа шир ч буй шал тгаа н
1	2	3	4	5	6
2017_03/03. Нийслэлийн агаар, орчны бохирдлын тухай / 2017-01-10 / УАБЗ-ийн зөвлөмж					
15	3.1	Аймаг, нийслэлийн ИТХ-ын хуралдаанаар орон нутгийн орчны бохирдлын асуудлыг хэлэлцэн холбогдох арга хэмжээг тусгай төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх	Орчны бохирдлыг бууруулах төлөвлөгөөг боловсруулсан. ИТХ-аар батлагдаагүй байна.	70	
16	3.2	Орчны бохирдлыг бууруулахад идэвхтэй оролцож хамтран ажиллах талаар нийт аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд хандан уриалга гаргах	Хаягдал цаасны хэрэглээг бууруулах зорилгоор Чингис хотод үйл ажиллагаа явуулдаг 50 аж ахуй нэгжид мэдэгдэл хүргүүлж хаягдал цаасныг хүлээн авч байна. Хаягдал цаасныг дахин боловсруулалтанд оруулна.	100	
2001_256. Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох талаар авах зарим арга хэмжээний тухай / 2001-11-03 / ЗГ-ын тогтоол					
18	6.6	Хог хаягдлыг цуглуулах, тэвэрлэх, устгах үйл ажиллагааны техник, технологийг 3-4 жилд багтаан шинэчлэх, дэвшилтэт менежментийг буй болгох арга хэмжээ авсугай;	Жаргалтхаан суманд хог хаягдал зөвөрлөх машин худалдаж авсан.	100	
2008_190. Журам батлах тухай (Ургамлын хорио цээр...) /2008-05-28/ ЗГ-ын тогтоол					
21	2	Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд М.Энхболд, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Ц.Ганхуяг, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.	2018 онд ургамлын хорио цээр тогтоох нөхцөл үүсээгүй.	100	
05_2011_174. Хилийн заагийг хэсэгчлэн тогтоох тухай / 2011-06-08 / ЗГ-ын тогтоол					
23	1	Алтны шороон ордын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн хэсэгт "Ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газрын хэсэгчлэн тогтоосон хилийн зааг"-ийг хавсралт ёсоор баталсугай.	Ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газрын хэсэгчлэн тогтоосон хилийн зааг орших 5 аж ахуй нэгжийг тусгай зөвшөөрлийг цуцалж дагаж мөрдөх журамд өөрчлөлт орсонтой холбоотой 4 тусгай зөвшөөрлийн тодорхой хэсгийг хэсэгчлэн сэргээгээд байна.	100	
2011_302. Усны экологи, эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай / 2011-10-26 / ЗГ-ын тогтоол					
24	2	Усны нөөцийн хэмжээ, чанар, хэрэглээний ач холбогдол, усны нөөцөд учирсан хохирлыг үнэлэхэд энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Усны экологи, эдийн засгийн үнэлгээ"-г мөрдөж байхыг Сангийн сайд С.Баярцогт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүх, Эрүүл мэндийн сайд С.Ламбаа, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Р.Содхүү, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.	Засгийн газрын 2011 оны 302, 2013 оны 326, 327 -р тогтоолын дагуу 14 ААН -д усны дүгнэлт гаргаж, 6 ААН-тэй ус ашиглуулах гэрээ байгуулсан.	100	
2012_07. Жагсаалт, журам батлах тухай / 2012-01-11 / ЗГ-ын тогтоол					

26	2	Ховор амьтан агнах, барих зөвшөөрөл олгох журмыг мөрдүүлэх ажлыг харьяа нутаг дэвсгэртээ зохион байгуулж ажиллахыг аймаг, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Дэлгэрхаан сумын Дэлгэрхаан агнуурын бүс, Баянхутаг сумын Баян-Уул агнуурын бүсээс тусгай зориулалтаар 2 толгой угалз, Баянмөнх сумын Язаар агнуурын бүсээс 5 толгой цагаан зээр агнуулах, Онон голын агнуурын бүсүүдэд 82 толгой тул, бусад загас 1320 толгой загас тусгай зориулалтаар баруулах, Батширээт сумын Номгон шувуу агнуурын бүсээс 150 толгой агнуурын шувуу тусгай зориулалтаар агнуулах гэрээг агнуурын бүс хариуцагч, жуулчлагч компаниуд болон тухайн сумын Засаг даргатай байгуулан дээрх зүйлийн амьтдыг агнуулж баруулсан.	100
2013_389. Төлөвлөгөө батлах тухай /улсын усны нөөцийн менежментийн/ / 2013-11-30 / ЗГ-ын тогтоол				
33	3	Улсын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгаж, гадаадын зээл, тусламж, төсөл хөтөлбөртэй уялдуулан санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Ч.Улаан, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Орон нутгийн төвийн хөрөнгийн БХНСЗ нөхөн сэргээх зардалд усны чиглэлээр зарцуулах 38.8 сая төгрөг батлан зарцуулж байна.	100
2014_43. Журам шинэчлэн батлах тухай / 2014-02-14 / ЗГ-ын тогтоол				
35	2	Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун, Сангийн сайд Ч.Улаан, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Хэнтий аймаг нь 2018 онд байгалийн нөөцөөс нийт 1150.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас ойгоос 85%, амьтнаас 50%, уснаас 35%, газрын төлбөрийн орлогоос 15%-ийг тус тус буцаан байгаль хамгаалах зардалд нийт 492.2 сая төгрөгийг зарцуулсан. Үүнээс аймгийн хэмжээнд 304.1 сая төгрөг, сумдад 188.1 сая төгрөгийг хуваарилан төлөвлөгөөний дагуу зарцуулж ажиллаа.	100
2014_222. Журам батлах тухай (түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах тусгай журам) / 2014-07-09 / ЗГ-ын тогтоол				
36	2	Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн сайд А.Гансүх, Уул уурхайн сайд Д.Ганхуяг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Тус аймгийн хэмжээнд нийт 19 хайгуулын тусгай зөвшөөрөл, 1 ашиглалтын тусгай зөвшөөрөл олгогдоод байна.	100
2014_307. Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай / 2014-09-18 / ЗГ-ын тогтоол				
37	2	Тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун, Сангийн сайд Ч.Улаан, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.	2018 онд Хэнтий аймгийн хэмжээнд 31780.5 м3 модыг ойгоос бэлтгэсэн ба нөөц ашигласны төлбөрийг 307 дугаар тогтоолыг үндэслэж, 169.0 сая төгрөг аймгийн төсөвт төвлөрүүлсэн.	100
2015_120. Журам, гэрээний загвар батлах тухай / 2015-03-30 / ЗГ-ын тогтоол				
40	2	Гол мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхайн сайд Р.Жигжид, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт тус тус даалгасугай.	2018 онд Батширээт сумын Гутайн даваа нэртэй талбайд үйл ажиллагаа явуулдаг "Айвуун тэс" ХХК нь Биологийн нөхөн сэргээлт 5.4 га талбайд, техникийн нөхөн сэргээлт 2.4 га талбайд тус тус хийж гүйцэтгэсэн.	80
2015_263. Журам батлах тухай / 2015-06-29 / ЗГ-ын тогтоол				
42	2	Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	"Хэнтий аймгийн Байгаль орчны тогтвортой хөгжлийн зорилт-2026" хөтөлбөрийг хэрэгжүүлэх хог хаягдлын талаарх зөв дадлыг төлөвшүүлэх замаар амьдралын тав тухтай орчин бүрдүүлэх хэд хэдэн арга хэмжээний хүрээнд хог хаягдал ашиглан "Бид бүтээгчид" бүтээл хийх уралдааныг аймгийн хэмжээнд зохион байгуулахад Биндэр сумын иргэн Нацагдорж нь хуванцар савны хайлшаар явган хүний замын хавтан хийж тэргүүлэн шагнал урамшуулал хүртлээ.	70
2017_98. Хөтөлбөр батлах тухай / 2017-03-20 / ЗГ-ын тогтоол				

65	3	Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдан зохион байгуулж, уялдуулан зохицуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг “Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо”-нд, хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Шинээр олгогдож буй газарт нүхэн жорлонгийн сайжруулалтыг зохион байгуулж ажиллах талаар нийт сумдын Засаг дарга нарт, газрын даамлуудад сурталчилж ажиллалаа. Агаарын бохирдлын төлбөрийг авто тээврийн хэрэгслээс 30.0 сая төгрөгийг урын зууханд түлдэг нүүрсний хэмжээгээр 12.6 сая төгрөгийг ногдуулж орон нутгийн татварын орлогод төвлөрүүлсэн байна. Ногоон байгууламжийн хэмжээг өмнөх оныхоос 20%-аар нэмэгдүүлсэн. Уурын болон усан халаагуурын нийт 180 зууханд 153646.5тн нүүрс, айл өрхийн 8123 зууханд 21379.5тн түүхий нүүрс шатаасан байна.	100
2017_151. Журам батлах тухай / 2017-05-24 / ЗГ-ын тогтоол				
71	4	Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг сурталчилан хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Ашигт малтмал, газрын тосны газрын Б.Баатарцогт нарт, журмын хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүүд, журмыг хэрэгжүүлэх ажлыг харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Тус аймгийн Галшар, Дархан, Бор-Өндөр, Цэнхэрмандал, Бэрх, Батноров, Норовлин, Баян-Адрага сумдын Бичил уурхайчдад, Бичил уурхайн нөхөн сэргээлт, Засгийн газрын 151 дугаар тогтоол, Хөдөлмөр аюулгүй ажиллагааны дүрэм журмын сургалтын 5 дугаар сард зохион байгуулаад байна. Өбл аёйёёй 7 пöи, 1 öипāиā 36 р°ö°ö°e 280 йд-èì äèø¿¿òýé ääèáöóèäāāāā äæèèèèæ ääèfā.	100
2018_43. Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай / 2018-02-06 / ЗГ-ын тогтоол				
95	1.18	нийслэлээс орон нутагт шилжин суурьшиж мал аж ахуй, газар тариалан эрхлэх сонирхолтой иргэдийг дэмжин ажлын байраар хангах, урамшуулах асуудлыг судлан, тодорхой санал боловсруулж 2018 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Засгийн газарт танилцуулахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	2018 онд 14 худгийн зөвшөөрөл гаргасанаас бэлчээрийн зориулалтаар 11 худгийн зөвшөөрөл олгож ажиллаа.	100
2018_171. Аялал жуулчлалын гол чиглэл батлах тухай / 2018-06-13 / ЗГ-ын тогтоол				
100	3	Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймаг, нийслэлийн аялал жуулчлалын чиглэлүүдийг аялал жуулчлалын гол чиглэлтэй нийцүүлэн баталж, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, дэд бүтцийн хөгжлийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Хэнтий аймаг нь түүхэн аялал жуулчлалын бүс нутаг болон хөгжиж байгаа бөгөөд Батноров суманд Андлалын өргөө цогцолбор, Биндэр суманд Монгол төрийн Их хуралдайн орд өргөө, Дадал суманд Мянганы суут хүн их Эзэн Чингис хааны цогцолборууд баригдах ажил эхлээд байна. Батноров, Биндэр суманд баригдаж буй цогцолборууд 2019 онд ашиглалтанд орно.	70
2018_209. Хөтөлбөр батлах тухай / 2018-07-04 / ЗГ-ын тогтоол				
101	3	Хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүр Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн төсөвт тусгах, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулах замаар санхүүжүүлж ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	БОАЖ-ын сайдын санаачилгаар “Хандлагаа өөрчилье” уриатай “Ногоон паспорт” аяныг эхлүүлээ. Дээрх төслийн хүрээнд Хэнтий аймагт 5 сургуулийн “Эко клуб”-ын 1200 хүүхдэд “Ногоон паспорт” тараагдлаа. Хог хаягдал ашиглан “Бид бүтээгчид” бүтээл хийх уралдааныг аймгийн хэмжээнд зохион байгуулахад Биндэр сумын иргэн Нацагдорж нь хуванцар савны хайлшаар явган хүний замын хавтан хийж тэргүүллээ. байгууллагаас гарсан цаасны	100

			хаягдлуудыг цуглуулах ажил хийгдсэн. Ерөнхий боловсролын сургуулийн багш сурагчдын дунд Тогтвортой хөгжлийн боловсролын олимпиадыг 12-р сард зохион байгуулж байна.		
2017_23. 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдөр 23 дугаар тэмдэглэл / 2017-05-24 / ЗГ-ын хуралдааны тэмдэглэл					
135	9.2	Харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд бичил уурхайгаар ашигт малтмал олборлож байгаа бүртгэгдээгүй нөхөрлөл болон нөхөрлөл, хоршоодын гишүүдийг бүртгэн зохион байгуулалтад оруулж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэл, сумын Засаг дарга нарт үүрэг болгов.	Тус аймгийн Галшар, Дархан, Бор-Өндөр, Цэнхэрмандал, Бэрх, Батноров, Норовлин, Баян-Адрага сумдын Бичил уурхайчдад, Бичил уурхайн нөхөн сэргээлт, Засгийн газрын 151 дугаар тогтоол, Хөдөлмөр аюулгүй ажиллагааны дүрэм журмын сургалтын 5 дугаар сард зохион байгуулаад байна. Өдл аёиёёё 7 ной, 1 ойнайга 30 г°дө°е аёёёёёёёёё аёёёёё аёёёё.	100	
136	10.3	Ашигт малтмалын тухай хуулийн 9.1.11-д заасны дагуу ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайн солбицлыг тогтоох талаар гарсан шийдвэрийг хэрэгжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов.	206 дөёёёёё дөёёёёёй дөпөөё ё°а°°дөёёй °д°а°°ё дднүй. Өбөёёй дөёёёёёё дөдөё пайаё оүдэ, үёёүй.	100	
2017_36. 2017 оны 8 дугаар сарын 17-ны өдөр 36 дүгээр тэмдэглэл / 2017-08-17 / ЗГ-ын хуралдааны тэмдэглэл					
140	16.3.2	ХҮЛ.3. 2.. Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор баталсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын хэрэгжилтийг бүрэн хангуулах, эвдэрсэн газрын тооллого хийх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов.	Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу 3 удаа, Засгийн газрын хамтарсан ажлын хэсэгтэй 1 удаа Батноров, Норовлин сумдын нутагт хууль бусаар байгалийн өнгөт чулуу олборлож байгаа иргэдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 55 кг өнгөт чулуу, газар ухах зориулалт бүхий багаж /хараацай гэх/ 37 ширхэг, лоом царил 11 ширхэг, хүрз 9 ширхэг, цахилгаан мотор 1ш, цахилгаан бутлагч 1 ширхэг хураан авч 19 иргэнд 3700.0 мянган төгрөгийн арга хэмжээ барагдуулахаар ажиллаж байна. Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн нөхөн сэргээлт хийсэн байдалд 2 удаа тандалт судалгаа хийж гүйцэтгэсэн. Өнөөгийн байдлаар гарсан зөрчилгүй. Он гарсаар аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 7 аж ахуйн нэгж уул уурхайн салбар дахь нөхөн сэргээлтийн ажлыг 17.09 га талбайд хийж аймгийн байгаль орчны нөхөн сэргээлт хүлээн авах комисст хүлээлгэн өгөөд байна.	100	
141	16.3.5	ХҮЛ.3. 5.. Ашигт малтмалын ашиглалт дуусаж, нөхөн сэргээлтийг бүрэн хийж орон нутагт хүлээлгэн өгсөн талбайд нөхөн сэргээлт хийх нэрээр болон хууль бусаар алт олборлогчдод зөвшөөрөл олгож байгааг таслан зогсоох, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайлан, тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө, байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөнд батлагдсан хэмжээнээс хэтэрсэн хүчин чадлаар олборлолт явуулахыг хориглох, үйл ажиллагаанд хяналт тавих арга хэмжээ авч ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүү, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов.	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний дагуу 7 аж ахуйн нэгж өөрсдийн хөрөнгөөр нийт 17.75 га-д техникийн нөхөн сэргээлт, 12.6 га-д биологийн нөхөн сэргээлт хийж хүлээлгэж өгсөн.	100	
2018_20. 2018 оны 5 дугаар сарын 2-ны өдөр 20 дугаар тэмдэглэл / 2018-05-02 / ЗГ-ын хуралдааны тэмдэглэл					

156	22.8	<p>XXII.8. . “Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахаар бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан гэрээлэгч компаниудын талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэр барихтай холбогдуулан газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг хууль тогтоомжид заасны дагуу дэмжиж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг, Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүү болон бүх шатны Засаг дарга нарт даалгав.</p>	<p>Тус аймгийн хэмжээнд “Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж байхгүй.</p>	*	
<p>2018_29. 2018 оны 7 дугаар сарын 4-ний өдөр 29 дүгээр тэмдэглэл / 2018-07-04 / ЗГ-ын хуралдааны тэмдэглэл</p>					
160	20.4	<p>Хэнтий аймгийн Батноров, Бор-Өндөр, Галшар, Дархан, Хэрлэн сумдын нутаг дэвсгэрт иргэд хууль бусаар өнгөт чулуу олборлож байгаа мэдээллийг шалгах үүрэг бүхий Ажлын хэсгийн дүнг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авахыг Засгийн газрын холбогдох гишүүд болон Хэнтий аймгийн Засаг даргад даалгав: 1. Өнгөт чулууг худалдаж авдаг, дамжуулдаг, тээвэрлэдэг, улсын хилээр хууль бусаар гаргадаг гэмт хэргийн сүлжээ, эх сурвалж бий эсэхийг шалган тогтоож, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх, байгалийн өнгөт чулууг олборлохтой холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох хуулийн төсөл боловсруулж Засгийн газарт оруулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид;</p>	<p>Аймгийн Засаг даргын баталсан 2018 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/75 дугаартай захирамжийн дагуу аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргаар ахлуулсан Цагдаагийн газар, Тагнуулын хэлтэс, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын хамтарсан ажлын хэсэг 2018 оны 04 дүгээр сарын 11-13-ны өдрүүдэд Хэнтий аймгийн Батноров сумын 3 дугаар багийн нутаг “Шаварт”, “Баавай”, “Ягааны хоолой Бүргэдийн өвөлжөө” гэх газруудад байгалийн өнгөт чулуу хууль бусаар түүж, олборлож байгаа иргэдийн үйл ажиллагааг шалгав. Хэнтий аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч нийт 24 иргэнд 4000 000 /дөрвөн сая/ төгрөгийн торгууль ногдуулж, барагдуулахаар ажиллаж байна. Байгалийн өнгөт чулуу хууль бусаар олборлосон, худалдсан, худалдан авсан нийт 109 кг чулууг хураан авсан .</p>	100	
161	20.3	<p>Газрын хэвлийд үүссэн хохирлын хэмжээг мэргэжлийн байгууллагаар тогтоолгож, эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээх арга хэмжээ авах, нутаг дэвсгэрийн хэмжээнд Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор баталсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын хэрэгжилтийг хангаж ажиллах, байгалийн өнгөт чулуу болон ашигт малтмалыг хууль бусаар хайх, олборлох үйл ажиллагааг таслан зогсоох талаар холбогдох арга хэмжээ авахыг Хэнтий аймгийн Засаг дарга Н.Ганбямбад даалгасугай.</p>	<p>2018 онд тус аймгийн хэмжээнд уул уурхайн нөлөөгөөр эвдэрхсэн орхигдсон газрын тооллогийн БОАЖЯамнаас эрх авсан “Мөнгөн марал” ХХК-аар гүйцэтгүүлж 333 га газар эвдрэлд орсон ба 11 тэрбум 76 сая төгрөгийн экологи-эдийн засгийн хохирол гарсан ба нийт нөхөн сэргээлтийн зардалд 37 тэрбум 734 сая төгрөгийн хөрөнг шаардлагтай байна.</p>	100	
				95.4	

БОАЖСайдтай аймгийн Засаг даргын 2018 онд байгуулсан гэрээний хэрэгжилтийг ханган ажиллана. /Хүснэгт-2/

Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах №18-021 тоот гэрээний 1 дүгээр хавсралт

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХООРОНД БАЙГУУЛСАН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГЫГ ОРОН НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ /2018 ОН/

ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ /АЙМАГТ ОЛГОГДСОН/

д/д	Хэрэгжүүлэх ажил	Хүрэх үр дүн	Хамрах хүрээ /тоо хэмжээ/	Хэрэгжүүлсэн хугацаа	Хариуцан хэрэгжүүлэгч	Зардал /мян.төг /	Биелэлт	Хувь
1	Ховор амьтад нутагшдаг газруудад биотехникийн арга хэмжээ авах /аргаль/	Зэрлэг амьтадыг хамгаалах, байгалийн жамаар өсөх нөхцөлийг бүрдсэн байна.	6 удаа	4-5 сар, 12 сард	Сумдын ЗДТГазар, нөхөрлөл үүд	6000,0	Ховор амьтад нутагшдаг Галшар, Бор-Өндөр, Мөрөн, Хэрлэн, Дэлгэрхаан, Дархан сумдын 6 газарт нийт 500 боодол өвс, 10 тн хужир шүү тавихаас 350 боодол өвс, 12,8 тн хужир тавьсан.	100
2	Агнуурын бүсүүдэд биотехникийн арга хэмжээ авах		6 удаа	12 сард	Сумдын ЗДТГазар, нөхөрлөл үүд	6000,0	Батширээт, Биндэр, Дадал, Цэнхэрмандал, Баян-Адрага, Өмнөдэлгэр сумдын агнуурын бүсүүдэд нийт 481 боодол өвс, 12 тн хужир тавьсан.	100
3	Онон Балжийн БЦГазарт биотехникийн арга хэмжээ авах		10 удаа	4-5 сард	Өнөрчийн гол ХХК, Онон Балжийн БЦГазар	10000,0	Онон Балжийн байгалийн цогцолборт газрын зэрлэг ан амьтад нийт 32 газарт 8 тн хужир, 730 боодол өвс тавьсан. 37 цэгт мониторинг хийсэн.	100
4	Аймгийн ерөнхий болон нарийвчилсан агнуур зохион байгуулалтыг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, ирүүлэх /мониторинг/	Тоо толгой, шилжилт тогтоогдоно	24 удаа	6-12 сард	Нөхөрлөл	7200,0	Мониторинг ажиглалт судалгааны гэрээ хийгдсэн бөгөөд 12 сард ажлыг хүлээн авна.	70

5	Онон голын агнуурын бүсүүдэд менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх /тэмдэгжүүлэлт/	Агнуурын бүсийн хил тодорхой болон хууль бус агнуур буурна.	5 удаа	7-8 сард	Онон голын загасчдын холбоо ТББ	10000,0	Батширээт, Биндэр, Баян-Адрага, Норовлин, Дадал сумдын Онон голын агнуурын бүсүүдэд нийт загас барихыг зөвшөөрөх тэмдэг 18 ширхэг, ус хөрс бохирдуулахыг хориглох тэмдэг 7 ширхэг, загас барихыг хориглох тэмдэг 11 ширхэг, мэдээллийн самбар 21 ширхэг, хилийн багана 11 ширхгийг тус тус хийсэн.	70
6	Батширээт суманд шувууны нарийвчилсан агнуур зохион байгуулалт хийх	Батширээт сумын агнуурын шувууны нөөц тогтоогдсоноор жилд ашиглах нөөц тодорхой болсон байна. Хамгаалалтын менежмент 5 жилээр батлагдан хэрэгжинэ.	1 удаа	7-12 сард	Эко үйлчилгээ ТББ	5000,0	Батширээт суманд Хавтгар, Ононгийн арал шувуу агнуурын бүсүүдэд нарийвчилсан агнуур зохион байгуулалтыг явуулан, менежментийн төлөвлөгөөг боловсруулсан. Батширээт сумын 2018.11.16-ны өдрийн ИТХ-н 23-р тогтоолоор агнуурын бүсийн хилийн цэсийг баталгаажуулан, 24-р тогтоолоор менежментийн төлөвлөгөөг дэмжсэн.	100
7	Гоц халдварт өвчний тандалт судалгааг хийх	Гоц халдварт шүлхий өвчний тандан судалгааг хийн эрсдэлтэй газрын судалгааг гаргасан байна.	4 удаа	12 сард	Аймгийн Мал эмнэлгийн газар	2000,0	Цагаан зээрийн гоц халдварт шүлхий өвчний тандан судалгаа хийх ажлын гэрээг аймгийн Мал эмнэлгийн газартай байгуулсан. Дархан, Баян-Овоо, Батноров, Норовлин, Баян-Адрага, Дадал сумдын 6 газраас 12 цусны дээж, 30 цуллаг, 6 тунгалгийн булчирхайн дээж авч шинжилгээнд хүргүүлсэн.	100
8	Цаг уурын автомат станц суурилуулах	Салхины хурд болон хөрс, агаарын температурыг автоматаар хэмжигдэнэ.	1 ком	7-9-р сард	Оллсолю шн ХХК	8500,0	Батширээт суманд цаг уурын автомат станцыг суурилуулаад байна. Уг багаж нь салхины хурд болон хөрс, агаарын температурыг автоматаар хэмжих зориулалт бүхий тоног төхөөрөмж юм.	100

9	Хэрлэн голын онцгой болон энгийн хамгаалалтын бүсээр нь тэмдэгжүүлэх ажил	Онцгой бүсийн тэмдэгжүүлэлт 5 сумдад хийгдсэн байна.	43ш	8.9-р сард	Хэрлэн дун ХХК	4300,0	Хэрлэн гол дагасан Баянхутаг, Хэрлэн, Мөрөн, Цэнхэрмандал, Дэлгэрхаан сумдын усан сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүсийг тэмдэгжүүлэх ажлын хүрээнд нийт 43 самбарыг суурилуулж ард иргэдэд мэдээлэл хүргэсэн.	100
10	Хэрлэн голын нөөц горим тогтоох зорилгоор Дэлгэрхаан сумын Хөмөлтийн гүүрний орчим гадаргын усны төвшин хэмжигч автомат багаж хэрэгсэл суурилуулна.	Усны түвшин хэмжигч автомат багаж сууриулагдсан байна.	1ш	7-9-р сард	Оллсолю шн ХХК	5000,0	Багажийн ашиглалт, хамгаалалтыг харгалзан аймгийн УЦУОШГ-ын даргатай зөвшилцсөнөөр Дэлгэрхаан сумын Хөмөлтийн гүүр орчимд биш Баянмөнх сумын гүүрэнд усны түвшин хэмжигч автомат багажийг суурилуулаад байна.	100
11	Ус зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх төхөөрөмж суурилуулах	Ус цэвэршүүлэх төхөөрөмж сууриулагдсан байна.	2ш	8-р сард	Ирмүүн бармат ХХК	20000,0	Баян-Овоо, Баянхутаг сумдад төвийн худагт ус цэвэршүүлэх төхөөрөмжийг суурилуулсан. Уг төхөөрөмж нь электрон буюу цахилгаан соронзон аргаар усны хатуулгийг зөөлрүүлэх багаж юм.	100
12	Аймгийн хэмжээнд хөрсний бохирдлын судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.	Хөрсний бохирдлын судалгааны тайлан гарсан байна.	1 багц	10-11-р сард	Грейн Ази Консалтинг ХХК	9800,0	Аймгийн хэмжээнд хөрсний бохирдлын судалгааг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж 23 сум, сууринд нийтдээ 122 цэгээс дээж авч шинжлүүлсэн.	100
13	Агаарын бохирдлын суурь судалгаа хийлгэх	Чингис хотын агаарын бохирдлын судалгаатай болно.	1 багц	3-р сард	Грейн ази консалтинг ХХК	5000,0	Чингис хотын агаарын бохирдлын судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн. Энэ нь агаарын бохирдлын суурь үнэлгээ болох ба цаашид авах арга хэмжээг тодорхойлох ач холбогдолтой.	100

14	Цөлжилттэй тэмцэх аймгийн дэд хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, тайлагнах ажлыг сайжруулах, цөлжилттэй тэмцэх ажилд зарцуулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх.	Хөрсний судалгаа 6 суманд хийгдсэн байна.	1 багц	2-4 улирал	УЦУОШГ	1000,0	Аймгийн хэмжээнд хөрсний агрохими цөлжилтийн судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн. Судалгаанд Биндэр, Батширээт, Өмнөдэлгэр, Жаргалтхаан, Цэнхэрмандал, Дэлгэрхаан сумдууд хамрагдсан.	100
15	Хог хаягдлын цэгийн хог хаягдлыг түрэх	Батноров сумын Бэрх тосгоны хог хаягдлын төвлөрсөн цэгт хуримтлагдсан хогны хэмжээ тодорхой хэмжээгээр буурсан байна.	1 багц	7-р сард	Өрнүүн дэлгэрэх хишиг ХХК	10000,0	Батноров сумын Бэрх тосгоны хог хаягдлын цэгт хуримтлагдсан хогийг түрж булаах ажлыг гүйцэтгэсэн. 10га талбайн хог хаягдлыг 200м урт шуудуунд түрж булнаар хөрсөн дээрх хог хаягдлын талбайн хэмжээг 50 хувь бууруулсан.	100
16	Ойжуулалтын үлдэгдэл санхүүжилт олгох /50%/	Акт үйлдэж санхүүжилт олгогдсон байна.	10 га	10-11 сар	“Биндэр ой” СДОА	3450,0	2017 онд Баян-Адрага сумын Баянгол нэртэй газар 10 га талбайд хийсэн ойжуулалтын ажлыг актаар хүлээн авсан.	100
17	Ойжуулалтын урьдчилгаа санхүүжилт олгох /50%/	Ойжуулалт хийгдсэн байна.	20 га	5-6 сард	“Хурханаг жибур” ХХК	6950,0	Баян-Адрага сумын Дуурлиг овооны ар нэртэй газар 20 га талбайд ойжуулалтын ажил гүйцэтгэж, урьдчилгаа санхүүжилт 6950,0 төгрөгийг олгосон.	100
18	Байгалийн сэргэн ургалтад туслах ажил	3 суманд БСУТА хийгдсэн байна.	30 га	5-9 сард	Хэнтий шинэс СДОА, Биндэр ой СДОА, Батширээт СДОА	6000,0	Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр суманд тус бүр 10 га талбайд байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг хийж гүйцэтгэсэн.	100
19	Ногоон байгууламжийн тасагт усны машин авах	Усны машин авсан байна.	1ш	5-6 сард	“МТМЧ”-ХХК	20000,0	Хэрлэн сумын “Өндөрхаан” ОНТҮГ-ийн Ногоон байгууламжийн тасагт усалгааны зориулалтаар тоногдсон ачааны авто машин нийлүүлсэн.	100

20	ОХУ-тай хиллэх улсын хилийн дагуу түймрээс хамгаалах харлуулсан шороон зурвас татах, сэргээх	58 км газарт зурвас татсан байна.	86 км	5-10 сард	ХЦ-0287 анги	20000,0	Хил дамнасан түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2014-2016 онд хилийн бүс нутаг болох Дадал, Биндэр сумдад түймрээс хамгаалах 175 км урттай, 10 м өргөнтэй харлуулсан шороон зурвас байгуулагдсан. 2018 онд дээрх зурвасын дагуу 30 км урттай газрыг 10 метрийн өргөнтэй, 28 км газрыг 20 метрийн өргөнтэйгөөр шинээр хагалж зурвасын өргөний хэмжээг нэмэгдүүлсэн.	100
	Шуурхай бүлэг	Шуурхай бүлэг гарсан байна.	2 удаа	4,5 сард	ОБГ	5000,0	Биндэр, Норовлин сумдад шуурхай бүлэг ажиллуулах гэрээг байгуулж шуурхай бүлгийг хуурайшилт ихтэй 4, 5 дугаар саруудад тогтмол ажиллуулсан.	100
	Бэлэн байдлын үзлэг	18 сум хамрагдсан байна.	1 удаа	3 сард	ЗДТГ, БОАЖГ, ОБГ	2000,0	Хэнтий аймгийн 18 сум 5 тосгонд аймгийн Засаг даргын нэрэмжит гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг зохион байгуулсан.	100
	Цаг агаарт зориудаар нөлөөлөх ажиллагаа	20 –оос дээш удаа нөлөөлсөн байна.	20 удаа	4-7 сард	УЦУОШГ	9500,0	Цаг агаарт зориудаар нөлөөлөх "Хэрлэн-бороо экспедиз" ажиллаж 2018 оны 4 -7 сард цаг агаарын нөхцөл бүрдсэн 13 процессод, 3 экспедиц давхардсан тоогоор 21 удаа тунадас нэмэгдүүлж ажиллаа. Үүнээс газар тариалангийн бүсэд 7 удаа, ойн түймрийг унтраахад дэмжлэг үзүүлэхэд 2 удаа, отрын бүсэд 2 удаа, бэлчээрийн бүс нутгаар 10 удаа тус тус тунадас нэмэгдүүлсэн.	100
21	Хортон устгалын багаж худалдан авах	бш утаат багаж худалдаж авсан байна.	1 багц	10 сард	“Содон түлхүүр” ХХК	10000,0	Ойн хортон устгалын 6HVB-25B маркын утаат шүршигч 6 ширхэг багажийг худалдан авсан.	100
22	Ойн хөнөөлт шавжийн тэмцлийн ажил	Тэмцлийн ажил хийгдсэн байна.	1000 га	9 сард	Цэнхэрмандал сумын ойн анги	8900,0	Цэнхэрмандал сумын Мөнхийн жалга нэртэй газрын 1000 га талбайд Сибирийн хүр эрвээхэйн тэмцлийн ажил хийгдсэн.	100

23	Мод үржүүлгийн талбайн өргөтгөлийн ажил	Усалгааны систем хийх, тоног төхөөрөмж авсан байна.	1 удаа	6-7 сард	ОМНН Холбоо	5000,0	Шинээр мод үржүүлгийн ажил эхлүүлж буй “Онон мөрний нөхөрлөлүүдийн нэгдсэн холбоо” ТББ-ийн үйл ажиллагааг дэмжиж мод үржүүлгийн газрыг өргөтгөх ажлыг хийж гүйцэтгэлээ. Өргөтгөлийн ажилд усалгааны багаж тоног төхөөрөмж худалдан авч угсарсан.	100
24	Мод үржүүлгийн газрын суулгац бүрийг тэмдэгжүүлэх	Мод үржүүлгийн газрын 1м –ээс дээш өндөртэй мод бүрт лац тэмдэглэгээ хийнэ.	1 удаа	6-8 сард	“Бат лац” ХХК	2000,0	Биндэр ой, Батширээт, Хэнтий шинэ сум дундын ойн ангиудын үржүүлгийн талбайд ургаж байгаа, үржүүлгийн талбайгаас зарагдаж буй шилмүүст модны суулгац бүрийг тэмдэгжүүлэх ажлыг зохион байгууллаа. Энэ ажлын хүрээнд 5000 ширхэг лац бүхий тэмдгийг шинээр хийлгэж, тэмдэгжүүлсэн.	100
25	Мод тарих өдөр	Мод тарих аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулсан байна.	2 удаа	5,10 сард	БОАЖГ	3000,0	Монгол улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигаар зарлагдсан “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийг тохиолдуулан аймгийн хэмжээнд нийт 21.2 мянган мод таригдсан ба нийт 2664 иргэн, 184 аж ахуйн нэгж, байгууллага оролцлоо.	100
26	Нөхөрлөл дэмжих	Мод үржүүлгийн газар байгуулах ажилд нь дэмжлэг үзүүлнэ.	1 удаа	9-10 сард	БОАЖГ	2000,0	Батширээтийн нөхөрлөлүүдийн холбооны үйл ажиллагааг дэмжиж мод үржүүлгийн газар байгуулах ажилд нь дэмжлэг үзүүлсэн.	100
27	Ногоон байгууламж нэмэгдүүлэх	3 суманд ногоон байгууламж нэгдсэн байна.	3 га	5-10 сард	Жавхлант гүрэм хоршоо, Цэвэрхэн Дадал бүлэг, Цэнхэрмандал СОА	15000,0	Баян-Овоо суманд 1 га, Цэнхэрмандал суманд 1 га, Дадал сумдад 1 га талбайд тус тус ногоон байгууламж нэмэгдүүлэн ажиллаа. Нийт 2000 мод таригдаж амьдралт 80% тай ургаж байна.	100
28	Ашиглалтад өртөмтгий 2 зүйл ургамлын тархац,	Хунчир, Дэрэвгэр	1 удаа	8-10 сард	“Хэнтий хунчир”	8775,4	Хэнтий аймгийн хэмжээнд ургаж байгаа Хунчир, Дэрэвгэр жиргэрүү ургамлын	

	нөөцийг тогтоох судалгаа хийх /хунчир/	жиргэрүү ургамлын нөөцийн судалгааны тайлан гарсан байна.			ТББ		тархац нөөцийн судалгааг хийж тайланг хүлээн авсан.	100
29	Баянхутаг сумын "Өвөр хөндий" Орон нутгийн хамгаалалттай газрын тэмдэгжүүлэлт	Хамгаалалттай газарт хамгаалалт сайжирсан байна	1 багц	9 сарын 15-аас 10 сарын 15 өдөр	"Цахиурт Өндөр" ХХК	8000,0	Тус аймгийн Байгалийн нөөц газрын ангиллаар орон нутгийн хамгаалалтад авсан Баянхутаг суманд орших "Өвөр хөндийн" орчмын газрын хилийн цэсийн 17 багана, 22 тэмдэг, 3 мэдээллийн самбарыг байрлуулсан.	100
30	Орон нутгийн төсвийн санхүүжилтэд эвдэгдэж орхигдсон газрын тооллого хийх, мэдээллийн санд оруулах ажлыг тусгах.	Эвдэрсэн газрын тооллогыг зохион байгуулснаар нийт эвдрэлийн экологийн эдийн засгийн үнэлгээг тооцож гаргах, нөхөн сэргээлтийн зардлыг тооцох, эрэмбэлэх нөхцөл бүрдсэн.	1 удаа	8-р сарын 15-аас 12 сарын 1 өдөр	"Мөнгөн марал" ХХК	8000,0	Орон нутгийн төсвийн хөрөнгийн санхүүжилтээр тус аймгийн 18 суманд уул уурхайн нөлөөгөөр эвдэрсэн газрын тооллого хийх, мэдээллийн санд оруулах ажлыг БОАЖЯамнаас эрх авсан "Мөнгөн марал" ХХК мэргэжлийн байгууллагаар хийлгэхээр 2018 оны 06 дугаар сарын 11-ны өдрийн БО/2018/41 дугаарт гэрээ байгуулан ажилласан. Урьдчилсан байдлаар нийт 18 суманд Уул уурхайн нөлөөгөөр эвдэрсэн эзэнгүй орхигдсон 35 нэгж талбарын 485,9 га талбай тоологдсон. Уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигч 43 нэгж талбарын 5085.8 га талбай, нийт Хэнтий аймгийн хэмжээнд 78 нэгж талбарын 5335.1 га талбай урьдчилсан байдлаар тоологдоод байна.	100
31	Дархан суманд хууль бус гар аргаар байгалын өнгөт чулуу түүсэн иргэдийн нөлөөгөөр эвдэрсэн газар 10 га газарт техникийн болон	10 газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийгдсэн байна.	1 багц	7-р сарын 15-аас 10-р сарын 1 өдөр	"Дэвжих дэлгэр эрхт" ХХК	15000,0	Дархан суманд хууль бус гар аргаар байгалийн өнгөт чулуу түүсэн иргэдийн нөлөөгөөр эвдэрсэн 10 га газарт техникийн нөхөн сэргээх ажлыг аймгийн Засаг даргын захирамжаар Дархан сумын Засаг даргын Тамгын	100

	биологийн нөхөн сэргээлт хийх					газарт эрхийг шилжүүлж, тендер сонгон шалгаруулалтаар шалгарсан ААН хийж гүйцэтгэсэн.		
32	Байгаль орчны эсрэг гэмт хэргийн зөрчлийг бууруулах зорилгоор нэгдсэн хяналт шалгалтыг/ БОАЖГ, Сав газар, Ойн анги, ТХГН-ийн ХЗ болон хууль хяналтын байгууллагууд ой, ан амьтан, ТХГН, уул уурхай, аялал жуулчлал, хог хаягдал гэх мэт бүх чиглэлээр хийх нөхцөл бололцоогоор хангах. Хяналт шалгалтын дүнг гаргаж мэдээлэх.		11 удаа	1-12 сард	БОАЖГ, МХГ, Цагдаагийн газар, Сумдын ЗДТГ	8800,0	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 48 дугаар зарлиг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн “2018 ойгоос мод бэлтгэх дээд хязгаар батлах тухай” 08 дугаар тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих, сум болон сум дундын ой ангийн 2018 онд олгосон ойгоос мод бэлтгэх эрхийн бичиг, мод модон материалын гарал үүслийн гэрчилгээний зарцуулалт, ойн нөхөрлөл ойн мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор хяналт шалгалтын ажлыг 4 дүгээр сард аймгийн БОАЖГ, Цагдаагийн газар, МХГ-ууд хамтран Жаргалтхаан, Цэнхэрмандал, Өмнөдэлгэр сумдад бүсчлэн зохион байгууллаа. Шалгалтаар Ойн тухай хууль зөрчсөн 2 иргэнийг илрүүлэн Цагдаагийн байгууллагад шилжүүлэн, мод бэлтгэлийн 4 ойн мэргэжлийн байгууллагад МХГ-аас торгууль ноогдуулсан байна.	100
33	Байгаль орчны багц хуулийн хэрэгжилтийг хангахад салбарын ажилчдын нийгмийн асуудлыг сайжруулах, ажлын байр, бие хамгаалах хэрэгсэл бусад шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах.	Байгаль хамгаалагч нарын ажиллах нөхцөл сайжирсан байна.	47 ш	5 сард		20000,0	Галшар, Баянмөнх, Өмнөдэлгэр, Батширээт, Дархан, Мөрөн сумдын 15 байгаль хамгаалагчдыг мотоцикл, цахилгаан бороохойгоор, богино долгионы станцаар хангаж, ажлын нөхцөл байдлыг сайжрууллаа.	100

34	ЕБСургуулийн багш, сурагчдын дунд "Тогтвортой хөгжлийн боловсролын олимпиад"-ыг зохион байгуулна.	Хүүхдүүдийн экологийн боловсрол нэмэгдсэн байна.	1 удаа	12 сард	ЕБС	2000,0	Олимпиадыг 12 сард зохион байгуулахаар удирдамж, хөтөлбөрийг боловсруулан ерөнхий боловсролын сургуульд хүргүүлээд байна.	100
35	Аймагт үйл ажиллагаа явуулж буй хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын хууль тогтоомжийг улирлын онцлогтой уялдуулан сурталчлах, олон нийтийн байгаль орчноо хамгаалах уламжлалт дадлыг сэргээх.	Иргэдэд мэдээлэл шуурхай түгээгдсэн байна.	жилдээ турш	1-12 сард	Хэнтий телевиз, Хэнтий мэдээ агентлаг	2000,0	Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь аймагт үйл ажиллагаа явуулдаг хэвлэл мэдээллийн байгууллагууд болох Шинэ зууны залуу Хэнтий ТББ-ын Хэнтий телевиз, Хэнтий мэдээ агентлагтай гэрээ байгуулан ажилласан.	100
36	Байгаль хамгаалах бүх чиглэлээр сургалт зохион байгуулах.	Мэргэжилтнүүд чадавхижсан байна	1 удаа	9 сард	БОАЖГ	3000,0	2018 оны 9-р сард Өмнөговь аймгийн Ханбогдод "Дүйцүүлэн хамгаалал" сургалтад БОАЖГазрын 11 албан хаагч хамрагдсан.	100
Бүгд						304175,4		98,33

ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ /СУМДАД ОЛГОГДСОН/

№	Хэрэгжүүлсэн ажлууд/ товч тодорхой/	Хүрэх үр дүн	Хамрах хүрээ /тоо хэмжээ/	Хэрэг жүүлсэн хугацаа	Хариуцан хэрэгжүүл эгч	Зардал /мян. төг/	Биелэлт	Хувь
Амьтны чиглэлээр								
1	Тарвагыг улсын хэмжээнд ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар агнахыг хориглосонтой холбоотойгоор нутагшуулах эрчимжүүлэх, хэмжээг авах аргын сэргээн ажлыг арга	Тарваганы тоо толгой нэмэгдсэн байна.	Баянхутаг, Дадал сумдад 2удаа	-	Мэргэжлийн байгууллага	0,0	Баянхутаг сумын агнуурын бүс нутаг Баянхүрээ ууланд 30 толгой, Дадал сумын агнуурын бүс нутаг Агац Гилбэр гэх газарт 15 толгой Монгол тарвага сэргээн нутагшуулах ажлыг 7-9-р сард хийхээр төлөвлөн нягтшил өндөртэй тарваган тахал өвчний голомтгүй газраас барихаар тусгай зөвшөөрлийн хүсэлтийг БОАЖЯ-д хүргүүлсэн. Тарвага нутагшуулах арга зүй батлагдаагүй тул улсын хэмжээнд 2018 онд сэргээн нутагшуулахыг БОАЖЯ-с хориглосон.	70
2	Биотехникийн ажил	Зэрлэг амьтадыг хамгаалах, байгалийн жамаар өсөх нөхцөлийг бүрдсэн байна	Баянхутаг, Мөрөн, Өмнөдэлгэр, Баянмөнх, Норовлин, Бор-Өндөр, Дадал, Баян-Адарга, Галшар, Дэлгэрхаан, Биндэр сумдад 16 удаа	3-5 сар, 11-12 сар	Сумдын ЗДТГазар, нөхөрлөл	13200,0	Ховор амьтад нутагшдаг Галшар, Бор-Өндөр, Мөрөн, Хэрлэн, Дэлгэрхаан, Дархан сумдын 6 газарт нийт 500 боодол өвс, 10 тн хужир шүү тавихаас 350 боодол өвс, 12,8 тн хужир тавьсан. Батширээт, Биндэр, Дадал, Цэнхэрмандал, Баян-Адрага, Өмнөдэлгэр сумдын агнуурын бүсүүдэд нийт 481 боодол өвс, 12тн хужир тавьсан. /12,0 сая төгрөг/ Өмнөдэлгэр, Баянхутаг, Мөрөн, Галшар, Жаргалтхаан сумдын нутагт нутагшдаг зэрлэг амьтдад 10 газарт 12тн хужир, 151 боодол өвс, 3 шуудай хивэг, 300кг ашигт долооц, 20 боодол тэжээлийн ургамал тавьж өгсөн. /Сумдад олгогдсон байгаль хамгаалах зардлаас 1,2 сая төгрөг зарцуулсан/	100
3	Агнуурын менежментийн төлөвлөгөө боловсруулах		2 агнуурын бүсүүдэд			1372,5	Дадал сумын Агац гилбэр, Цээнэтэй агнуурын бүсүүдэд нарийвчилсан агнуур зохион байгуулалт хийн менежментийн	100

							төлөвлөгөөг “Уламжлалт ав” мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн.	
4	Агнуурын амьтны мониторинг судалгаа хийх	Амьтдын тоо толгой, шилжилт хөдөлгөөн тогтоогдоно	Баянмөнх, Норовлин, Дадал, Дэлгэрхаан, Биндэр сумдад будаа	5-11 сард	Агнуурын бүс хариуцагч ид, нөхөрлөл, сумдын ЗДТГ	3334,0	<p>1. Дадал сум Цээнэтэй, Агац Гилбэр агнуурын бүсүүдэд мониторинг ажиглалт судалгааг хийлгэхээр /агнуур зохион байгуулалт/ “Уламжлалт ав” ХХК-тай гэрээ байгуулан нарийвчилсан агнуур зохион байгуулалт, менежементийн төлөвлөгөөг боловсруулсан. 2,8 сая төгрөг</p> <p>2. Баянмөнх сумын Язаар уул орчмын агнуурын бүс нутагт Язаарын 3 овоот нөхөрлөл, БОХУБайцаагч, байгаль хамгаалагч нар хамтран 2018.05.08-нд ховор амьтдад тооллого зохион байгуулсан. Тооллогоор Их салхит, Бага салхит, Дөрвөлжин, Гурван овоот, Барчгар, Дулаан, Агуйт, Баруун дөрвөлжин зэрэг газрууд хамрагдсан. Тооллогоор 8 угалз, 21 хонь, 18 хурга, 2 буга тус тус тоологдсон. 0,034 сая төгрөг зарцуулсан.</p> <p>3. Норовлин сумын Нарстай, Хөх Асгана, Түмэнхаан, Энгэрбулаг, Бэрх нөхөрлөлийн 11 гишүүн, идэвхтэн байгаль хамгаалагч нарт тарваганы мониторинг ажиглалт судалгаа хийх дадлага ажлыг зохион байгуулсан. 0,5 сая төгрөг зарцуулсан.</p>	100
5	Эргүүл хяналт шалгалт зохион байгуулах	Хууль бус ан буурна	Норовлин, Өмнөдэлгэр, Баян-Овоо, Хэрлэн, Дархан, Дадал, Баян-	2-12 сард	Сумдын ЗДТГ, Цагд аагийн газар,	5200,0	1. Баян-Адарга сумын БОХУБ, байгаль хамгаалагчид, хэсгийн төлөөлөгч, Онон голын загасчдын клубын гишүүд хамтран хууль бус ан агнууртай тэмцэх эргүүл шалгалтын хүрээнд загас, бор гөрөөс, зээр гэх зэрэг амьтдад эргүүл шалгалтыг 4-5 сард, 7-10 сард нийт 4 удаагийн давтамжтайгаар хийсэн. Хяналт	

			Адарга, Цэнхэрман дал, Батноров сумдад 27удаа		МХГ, БОАЖГ		шалгалтын хүрээнд нийт 15 зөрчил гаргасан иргэний галт зэвсгийг хурааж цагдаагийн байгууллагад шилжүүлсэн. 57 ширхэг хавхыг хураан устгалд оруулсан. 1,6 сая төгрөг 2. Дадал сумын байгаль хамгаалагч, БОХУБ, хэсгийн төлөөлөгч, Онон голын загасчдын клуб, ОББЦГХЗахиргаа хамтран 5-6 сард Онон, Балж голуудад эргүүл шалгалтыг 2 удаа явуулсан. хяналт шалгалтын хүрээнд илэрсэн зөрчил гараагүй. /0,2 сая төгрөг./ 3. Цэнхэрмандал сумын БОХУБ, байгаль хамгаалагч нар 4-р сарын 25-27 өдөр Согоот багийн Моностой, Цагаан даваа гэх газруудад хууль бус ангийн эргүүл шалгалт хийсэн зөрчил илрээгүй. 0,11 сая төгрөг. 4. Норовлин сумын БОХУБ, байгаль хамгаалагч МХГазар, сумын Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг 10 сард хамтарсан эргүүлийг 18 удаа зохион байгуулсан. Зөрчлийн тухай хуулиар 3 зөрчилд арга хэмжээ авч 119 иргэнд хууль сурталчилсан. 0,6 сая төгрөг 5. Жаргалтхаан сумын БОХУБ, байгаль хамгаалагчид 300 ш брошур тарааж, 9 тарвага агнасан зөрчил илрүүлсэн. 2,7 сая төгрөг зарцуулсан. Жаргалтхаан суманд 9 толгой, Дэлгэрхаан суманд 8 толгой, Батноров суманд 6 толгой буюу нийт 23 толгой тарвага агнасан зөрчил илрүүлсэн.	100
6	Амьтны тухай хуулийг хэрэгжүүлэх, сургалт сурталчилгаа хийх	Иргэдийн хуулийн мэдлэг дээшилнэ	Жаргалтхаан, Баян-Овоо, Өмнөдэлгэр,	2-12 сард	Сумын ЗДТГ,Төсө	876,3	1. Баян-Адарга сумын 2,4-р багийн 15 иргэдэд Ан агнуур болон зөрчлийн тухай хууль сурталчлах ажлын хүрээнд 1 удаа сургалт зохион байгуулсан. 2. 2-р сард Өмнөдэлгэр сумын төвийн	70

			Батширээт, Баян- Адарга сумдад 5 удаа		л хөтөлбөр		багийн 40 иргэнд Амьтны тухай хууль холбогдох журмаар сургалтыг БОХУБ, байгаль хамгаалагч нар явуулсан.	
	дүн					23982,8		90,0
Усан хангамжийн чиглэлээр								
7	Нуур цөөрмийн далан засварлах	Даланг засварласан байна.	Хэрлэн суманд 1удаа	10-р сард	Сумын ЗДТГ	1200,0	Хэнтий-Ус ХХК-тай хамтран Нарийн голын тохой нэртэй газарт харьцуулсан нөхөн сэргээлтээр загас үржүүлгийн нуур цөөрмийн даланг хэлбэржүүлэх ажил хийгдсэн.	100
8	Булгийн эх хашиж хамгаалах	Булгийн эх хашигдсан байна.	Хэрлэн, Мөрөн, Өмнөдэлгэр, Баян-Овоо, Цэнхэрмандал, Норовлин, Батноров, Дэлгэрхаан сумдад 11удаа	2-4-р улиралд	Сумын ЗДТГ	10130,0	Аймгийн хэмжээнд нийт 8 булгийн эхийг хашиж, 4 булгийн хашааг сэргээн зассан. Норовлин сум Бага бүрдийн эхийг хашиж, Өндөр дов, Мөстийн булгийн эхийг сэргээн зассан. Хэрлэн сум Чулуутын булаг, Өвдгийн булгийн эхийг хашиж хамгаалсан. Баян-Овоо суманд Мухар булгийн хашааг сэргээсэн. Дэлгэрхаан суманд Бөөр булгийн эхийг хашаажуулсан. Цэнхэрмандал сумын Тосонгийн амны адгийн булаг, Бургастайн амны булаг, Өмнөдэлгэр сумын Зүрхийн булаг, Мөрөн сумын Эхэн ус, Рашаант булгийн эхийг хамгаалсан.	100
9	Унд ахуйн худагт гадна тохижилт хийх, засварлах	Унд ахуйн худагт засвар хийгдсэн байна.	Норовлин, Бор-Өндөр Галшар сумдад 5удаа	9-р сард	Сумдын ЗДТГ	13160,0	Бор-Өндөр сумын Хамтын хүч нөхөрлөлийн гишүүд ундны худагт 2*2,4 м хундаам цутгаж, шинээр цонх, хаалга суулгах, гадна пасад засварлаж, 220 вольтын хүчдэл татсан. Норовлин сумын 3 худгийн гадна өнгөлгөөний ажил хийгдэж, 1 худгийн хашааг бүрэн шинэчилж, 1 худгийн хаалга цоожийг	100

							засварлаж, самбар, хогийн сав байрлуулсан. Галшар сумын төвийн 1 ундны худагт цэвэршүүлэх төхөөрөмжийн шүүлтүүрийг сольж, угсралтыг шинэчилсэн.	
10	Ундны усны шинжилгээнд хамруулах	Шинжилгээнд хамрагдсан байна.	Норовлин, Дархан, Биндэр сумдад 9 удаа	жилдээ	Сумдын ЗДТГ	758,0	Аймгийн Мэргэжлийн хяналтын газарт 18 сумдын төвийн ундны худгийг тус бүр 1 удаа шинжилгээнд хамруулсан. Лаборатори ажиллахгүй болсон шалтгаанаар дараагийн шатны шинжилгээнүүд хийгдээгүй болно. Биндэр суманд орших сахарын рашааныг ШУАкадемийн Биологи химийн хүрээлэнгийн ажилтнуудтай хамтран найрлагыг тодорхойлуулахаар хүргүүлсэн. Хариу ирээгүй.	100
11	Дэлхийн усны өдрийн тэмдэглэн өнгөрүүлэх, сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах	“Дэлхийн усны өдөр”-ийг тэмдэглэсэн байна	Хэрлэн, Баянхутаг, Баян-Адарга, Өмнөдэлгэр, Баян-Овоо, Норовлин сумдад	3-р сард	БОАЖГ, Сумдын ЗДТГ, байгаль хамгаалагчид	866,0	“Дэлхийн усны өдөр”-ийг сум тус бүрт зохион байгуулсан. Сургалтыг цэцэрлэгийн 4-5 насны, 5-6, 8-9, 11-12 дугаар ангийн нийт 1432-н сурагчдын дунд Усны үнэ цэнэ зургийн уралдаан, Усны гайхамшиг ба сонин хачин сэдвээр мэдээлэл хүргэж, эссэ бичлэгийн болон АХА асуулт, хариултын тэмцээнийг Хэрлэн голын СГЗ, МХГ, Хэнтий-Ус ХХК-тай хамтран тус тус зохион байгуулж, оролцогчдоос 6 сурагчдыг шагнаж урамшуулсан. Мөн 6 сумдад усны чиглэлээр сурталчилгаа, сургалт зохион байгуулж, гарын авлага 750ш тараах ажлыг гүйцэтгэсэн. “Усны нөөц, хэрэглээ, бохирдол” сэдвээр 33 иргэд 214 сурагчдыг сургалтад хамруулсан.	100
12	Рашааны эх болон усан сан бүхий газрын хамгаалалтын бүсийг тогтоож тэмдэгжүүлэх /Замт, Алтанбулаг, Улаан	Зарим усан сан бүхий газрыг хамгаалалтын бүсээр тэмдэгжүүлнэ	Норовлин суманд 1 удаа	6-р сард	Сумдын ЗДТГ	120,0	Замт болон Алтанбулгийн рашааны дээжийг авч аймгийн МХГазарт хүргүүлсэн. Энгийн хамгаалалтын бүсээр тэмдэгжүүлэх ажил хийгдэж байна. Төсвийг бүрэн зарцуулсан.	100

	өндөр /							
13	Усны сав газрыг нөхөн сэргээх замаар усны нөөцийг нэмэгдүүлэх, Улз голын сав газарт төгөл байгуулах	Улз голын сав газарт төгөл байгуулагдсан байна.	Норовлин суманд 1 удаа	5-р сард	Сумын ЗДТГ	950,0	Улз голын бага бүрдийн эхийг хашиж, 660 ширхэг мод бут тарьж, ногоон төгөл байгуулсан.	100
14	Усан сан бүхий газрын орчны цэвэрлэгээний зохион байгуулах ажил	Цэвэрлэгээний ажил зохион байгуулагдсан байна.	Хэрлэн, Өмнөдэл гэр, Батширээт, Дархан, Норовлин, Цэнхэрман дал, Баянмөнх, Биндэр суманд 24 удаа	5-10-р сард	Сумдын ЗДТГ	3418,0	Нийт 8 суманд тус бүр 2 удаа цэвэрлэгээ зохион байгуулж, Нийт 37 тн хог хаягдлыг цэвэрлэсэн. Хэрлэн сум-Хэрлэн гол орчмын цэвэрлэгээг сумын “Нохой сонирхогч клуб”-ын 11 гишүүн 8га талбайн 2м ³ хог хаягдлыг, Хэрлэнгийн цэнхэр алс ТББ-ын 22 иргэдтэй хамтраад 3 га талбайн 1м ³ хогийг цэвэрлэх ажлыг зохион байгуулсан. Өндөрхаан хот тохижилт ОНТҮГ-ын 17 иргэн 20 га талбайн 9м ³ хогийг тус тус цэвэрлэсэн. Норовлин суманд улз голд 1 хогийн сав хийсэн. Өмнөдэлгэр сум Айраг нуур бусад газрын цэвэрлэгээний ажлыг Хэсгийн ахлагч нар болон Модон цаг ХХК-тай хамтран зохион байгуулж 6 тн хог хаягдлыг цэвэрлэсэн. Баянмөнх сум Хэрлэн голын урд хэсгээр 3 км талбайн 10 тн хог хаягдлыг 15 хүн цэвэрлэв. Цэнхэрмандал суманд 2 удаа уст цэгийн цэвэрлэгээг зохион байгуулж 12 тн хог хаягдлыг цэвэрлэхэд төсөвт байгууллагын 67 албан хаагч оролцсон.	100
15	Гүрмийн нуурын тохижилт тэмдэгжүүлэлт	Тэмдэг тавигдсан байна.	Баян-Овоо суманд 1 удаа	11-р сард	Сумдын ЗДТГ	300,0	Гүрмийн нууранд 1ш санамжийн самбар суурилуулсан.	100
16	Хэрлэн голын хамгаалалтын бүс, эрүүл ахуйн бүс тэмдэгжүүлэх	Самбар суурилуулсан байна.	Баян-Овоо суманд 1 удаа	11-р сард	Сумдын ЗДТГ	250,0	Хэрлэн голын эрүүл ахуйн бүсэд хориотой болон хамгаалалтын бүсэд анхааруулах самбар 50м зайд хийж суурилуулсан.	100

17	Ухуулга сурталчилгааны самбар хийж байрлуулах, Гарын авлага тараах	Ухуулга сурталчилгааны	Баянмөнх, Өмнөдэлгэр, Цэнхэрмандал сумданд 7 удаа	2,3,4-р улиралд	Сумдын ЗДТГ	1625,0	Цэнхэрмандал суманд 2 удаа, Өмнөдэлгэр суманд 2 удаа, Баянмөнх суманд 2 удаа сурталчилгааг хийж нийт 280 гарын авлага хийж, багийн өрхүүдэд тараагдсан. Хэрлэн гол дагуу Баянмөнх суманд мэдээллийн самбар 5 байршуулсан.	100
18	Усны нөөцийг хамгаалах судалгааны ажил	Тооллого хийгдсэн байна.	Дадал, Жаргалтхаан суманд 2 удаа	8-р сард	Сумдын ЗДТГ	210,0	Дадал, Жаргалтхаан сумд нутаг дэвсгэр дэх нийт уст цэгийн тооллогыг хийж гүйцэтгэсэн.	100
19	Нийтийн эзэмшлийн талбайд хог хаягдлын түр хадгалах сав байршуулах.	Хог хаягдлыг түр хадгалах сав байршуулсан байна	Баянмөнх суманд 5ш	5-р сард	Сумын ЗДТГ	150,0	Оюусоёмбо ХХК-тай зөвшилцсөнөөр Хэрлэн голын дагуу 5ш хог хаягдал түр хадгалах савыг байрлуулсан.	100
20	Био жорлон байгуулах	Био жорлон бий болно.	Бор-Өндөр суманд 1ш	7-р сард	ЗДТГ	8500,0	Канад кастел ААН-тэй гэрээ байгуулж, 8,5 сая ₮ буюу 50 хувиар санхүүжүүлсэн боловч ажил хийгдээгүй.	40
21	Ундны усны зөөврийн сав нийлүүлэх	Айл өрхөд стандартад нийцсэн усны сав нийлүүлнэ	Бор-Өндөр суманд 600ш	11-р сард	Сумын ЗДТГ	8000,0	Усны сав нийлүүлэх ажлыг өөрчлөн Автомат худгийн төхөөрөмжийг 1-р багийн худагт суурилуулах ажлаар сольж, Баялаг говь ХХК-тай гэрээ байгуулж, ажлыг гүйцэтгэсэн.	100
22	Ус цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулах	Ус цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулагдана.	Бор-Өндөр суманд 1ш	3-4-р сард	Сумын ЗДТГ	3000,0	Дорны Эх ХХК-тай гэрээ байгуулснаар сургуулийн дотуур байранд PUROFLO брэндийн ус цэвэршүүлэгч төхөөрөмж суурилуулсан.	100
23	Худаг гаргах	Худаг гаргасан байна.	Бор-Өндөр суманд 2ш	11-р сард	Сумын ЗДТГ	6000,0	Тус сумын 1, 3-р багуудад малчдын хэрэгцээнд 2 худаг гаргуулсан.	100
24	Усан хангамжийн цэгийг хамгаалах	Усан санг хашуулсан байна	Бор-Өндөр суманд 1ш	9-р сард	Сумын ЗДТГ	800,0	Бор-Өндөр сумын 3, 4-р багийн 3 худгийн гадна талыг төмөр сараалжин 27мкв хашаагаар хашсан.	100
	дүн					59437,0		96,66
Ойн нөөцийг хамгаалах нөхөн сэргээх								

25	Сумын ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах	8 сумын ОМТ батлагдсан байна.	Ой бүхий 8 суманд	5-10 сард	СЗДТГ, ойн анги	10700,0	Хэнтий аймгийн Ой бүхий Цэнхэрмандал, Жаргалтхаан, Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр, Баян-Адрага, Дадал, Норовлин сумдын ойн менежментий төлөвлөгөө тус бүрийг мэргэжлийн байгууллагаар боловсруулж аймгийн Засаг даргаар батлуулсан. Дээрх нэр бүхий сумдууд нь Ойн менежментийн төлөвлөгөөний дагуу ойн аж ахуйн арга хэмжээг төлөвлөн ажиллаж байна.	100
26	Ойн хөнөөлт шавьж устгах тэмцэх арга хэмжээ, су рин судалгаа хийх	6 суманд ойн хөнөөлт шавьжийн тэмцлийн ажил хийгдсэн байна.	Баян-Адрага, Биндэр, Батширээт, Дадал, Цэнхэрмандал, Норовлин суманд	5,9 сард	Биосфер экологийн нийгэмлэг, СЗДТГ	5742,8	Биосфер экологийн нийгэмлэг, “ОСХТ” – УТҮГ-тай гэрээ байгуулсны дагуу Цэнхэрмандал, Жаргалтхаан, Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр, Баян-Адрага, Дадал, Норовлин, Дэлгэрхаан сумдад Ойн хөнөөлт шавьжийн тархалтын судалгааны ажил хийгдсэн.	100
27	Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хамгаалах ажил	Ой хээрийн түймрээс сэргийлэх ажил хийгдсэн байна.	Биндэр, Батширээт, Цэнхэрмандал, Өмнөдэлгэр, Норовлин суманд 5удаа	4-5, 9-10 сард	СЗДТГ	6300,0	Ойн хээрийн түймрээс хамгаалах урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газартай хамтран 5000 мянган ширхэг санамж боршурыг хэвлэн шинээр гарсан Зөрчлийн тухай хуулийн заалтуудыг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулсан. Батширээт, Биндэр, Норовлин, Өмнөдэлгэр, Цэнхэрмандал суманд ой хээрийн түймрээс хамгаалах сургалт, сурталчилгаа, мэдээллийн самбар зэргийг хийсэн.	100
28	Хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх зөрчил бууруулах хяналт шалгалт хийх	Хяналт шалгалтын ажлыг 2 оос доошгүй удаа зохион байгуулна.	Ой бүхий сумдууд	Жилийн турш	БОАЖГ, Цагдаагийн газар, МХГ, СЗДТГ	4210,0	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 48 дугаар зарлиг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн “2018 ойгоос мод бэлтгэх дээд хязгаар батлах тухай” 08 дугаар тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих,	

							хууль бус мод бэлтгэлийг бууруулах зорилгоор нэгдсэн хяналт шалгалтын ажлыг БОАЖГ, Цагдаагийн газар, МХГ-ууд 4 болон 11 сард 2 удаа зохион байгуулсан. Шалгалтаар Ойн тухай хууль зөрчсөн 2 иргэн, 2 ойн мэргэжлийн байгууллагыг илрүүлэн Цагдаагийн байгууллагад шилжүүлсэн. Мөн Батширээт, Дадал, Цэнхэрмандал, Өмнөдэлгэр, Норовлин, Биндэр сумд хууль бус мод бэлтгэлийн хяналт шалгалтыг сумын хэмжээнд зохион байгуулан ажиллаа.	100
29	Мод үржүүлгийн газар өргөтгөх	2 мод үржүүлгийн газарт өргөтгөл хийх	Батширээт, Өмнөдэлгэр суманд 2 удаа	5-10 сард	Онон-мөрний ННХолбоо, Батширээт ННХолбоо	7000,0	Дадал суманд байрлах Онон мөрний нөхөрлөлүүдийн нэгдсэн холбооны "Хүрэн шугуй" мод үржүүлгийн газарт усалгааны систем тавих өргөтгөл, мөн 2017 оны шилдэг нөхөрлөлийн холбоог дэмжих зорилгоор Батширээт суманд нөхөрлөлийн мод үржүүлгийн газар байгуулахад дэмжлэг үзүүлсэн.	100
30	Хэлэлцүүлэг сургалт	Сургалт зохион байгуулагдсан байна.	2 удаа	2,6 сард	СЗДТГ, СДОА	1286,0	2018 оны 01-02 сард Байгалийн нөөцийн хамтын менежментийн тогтолцооны өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлууд төрөөс энэ чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар зөвлөгөөнийг ой бүхий 8 сумд тус бүрдээ зохион байгууллаа.	100
31	Мод тарих, ногоон байгууламж нэмэгдүүлэх	Ногоон байгууламжийн талбайн хэмжээ 6 га –аар нэмэгдсэн байна.	Аймгийн хэмжээнд	5,10 сард	БОАЖГ, СЗДТГ	10325,0	2018 онд аймгийн хэмжээнд 6.5 га талбайд ногоон байгууламж нэмэгдэж, нийт 25.0 мянган мод таригдсан. Мөн ОНТХ -өөр Баян-Овоо суманд 1 га, Цэнхэрмандал суманд 1 га, Дадал сумдад 1 га талбайд тус тус ногоон байгууламж нэмэгдүүлэн ажиллаа. Нийт 2000 мод таригдаж амьдралт 80% тай ургаж байна. Баян-Адрага, Биндэр, Норовлин, Өмнөдэлгэр сумдад нийт 25 га талбайд	100

							ойжуулалтын ажил хийгдсэн.	
32	Ойн нөхөрлөлүүдийг дэмжих ажил	Нөхөрлөлийг дэмжих ажил хийгдсэн байна.	Дадал, Батширээт суманд 2 удаа	5-10 сард	БОАЖГ	9300,0	Батширээт сумын нөхөрлөлийн холбооны дэргэд шинээр мод үржүүлгийн газар байгуулах ажилд 2,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Дадал суманд байрлах Онон мөрний нөхөрлөлүүдийн нэгдсэн холбооны "Хүрэн шугуй" мод үржүүлгийн газарт усалгааны систем тавих өргөтгөлийн ажилд дэмжлэг үзүүлсэн. Аймгийн Засаг даргын ивээл дор 2 дахь жилдээ "Нөхөрлөл хөгжил" 2018 наадмыг зохион байгуулж оны шилдэг нөхөрлөлүүдийг шалгаруулсан. Үүнд: Биндэр сумын "Дэлгэр-Онон" ойн нөхөрлөл 1 байр, Батширээт сумын "Онон харуул" нөхөрлөл 2 -р байр, Батширээт сумын "Хамтын хүч" нөхөрлөл 3-р байранд тус тус шалгарч өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдсан.	100
33	Нарсан ойн зам бий болгож Ойн парк байгуулж ойн аялал жуулчлал хөгжүүлнэ	Нарсан ойг нөхөн сэргээх арга хэмжээ хийгдсэн байна.	Баян-Адрага суманд 1 удаа	5 сард	СЗДТГ	400,0	Сумын ААН, Байгууллага, нөхөрлөл, иргэд өөрсдийн тарьц суулгацыг ашиглан нарсан ойд мод тарьж нарсан коридор байгуулсан.	100
34	Хуш модны самрын цэцэглэлт, болцын судалгаа судалгаа авах	Судалгаа хийгдсэн байна.	Батширээт суманд 2 удаа	6,8 сард	Батширээт СДОА	400,0	"Батширээт" СДОА хуш модны самрын цэцэглэлтийн болон болцын үеийн судалгааг хийж гүйцэтгэн тайлан мэдээг "Ой судалгаа хөгжлийн төв"-д хүргүүлсэн.	100
35	Хэрлэн сумын бургасан ойд арчилгаа, цэвэрлэгээний ажил хийх	Арчилгаа цэвэрлэгээний ажил хийгдсэн байна.	Хэрлэн суманд 10 га	06 сард	Батширээт СДОА	1500,0	2018 оны 06 дугаар сарын 18-20-ны өдрүүдэд Хэнтий аймгийн Чингис хотод "Хэрлэн голын бургасан ойг нөхөн сэргээх, хамгаалах, арчлах, ашиглах нь" сэдэвт сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулсан. Мөн Хэрлэн сумын бургасан ойн 10 га талбайд арчилгаа, цэвэрлэгээний ажил	100

							хийгдсэн.	
36	Бусад арга хэмжээнд	Төлөвлөгдсөн арга хэмжээ хийгдсэн байна.	Тухайн суманд	Жилийн турш	СЗДТГ	6900,0	Биндэр сум хяналт шалгалтын ажилд зориулж нисдэг камер, Цэнхэрмандал сум мотоцикль худалдаж авсан. Дадал сумын Дэлүүн болдогт тэмдэгжүүлэлт, тохижилтын ажлыг нэмж хийсэн.	100
	дүн					64063.8		100
	Бүгд					147483,5		95,55

Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт
хамтран ажиллах №18-021 тоот гэрээний
2 дугаар хавсралт

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЛБАРЫН ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭХ АЖЛУУД**

№	Хэрэгжүүлэх ажлууд	Хүрэх үр дүн	Хамрах хүрээ/Тоо хэмжээ	Хэрэгжүүлсэн хугацаа	Хариуцан хэрэгжүүлэгч	Зардал мян.төг	Биелэлт	Хувь
1. Ногоон хөгжлийн бодлогыг хөгжүүлэх чиглэлээр:								
1	Ногоон хөгжилд суурилсан хэтийн зорилт бодлогын баримт бичиг, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах.	2018 оны төлөвлөгөөний хэрэгжилт хангагдана		2-12 сар	БОАЖГ, Сумдын ЗДТГ	0	Хэнтий аймгийн ногоон хөгжилд суурилсан тогтвортой хөгжлийн хэтийн зорилт 2026 номын 2000 ширхгийг аймгийн ЗДТГазар хэвлүүлэн 18 сумдад хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажилласан. 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 90 хувьтай хэрэгжсэн	90
2	Олон нийтэд чиглэсэн Тогтвортой хөгжил, ногоон хөгжлийг сурталчлан таниулах, мэдлэг мэдээлэл олгох үйл ажиллагаандаа Тогтвортой хөгжлийн боловсролын цахим гарын авлагыг ашиглах http://ncle.mn/esd/ .	Цахим гарын авлагад нэвтрэх иргэдийн хандалт нэмэгдсэн байна.		2-12 сар	БОАЖГ, Сумдын ЗДТГ	0	Тогтвортой хөгжлийн боловсролын цахим гарын авлагыг иргэд олон нийтэд таниулж, тухай бүр ашиглан ажиллаж байна.	70
2. Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийг хамгаалах чиглэлээр:								
3	Мал, зэрлэг амьтны гоц халдварт өвчнөөс	Гоц халдварт шүлхий өвчний	4 удаа	12 сард	Аймгийн Мал	2000,0	Цагаан зээрийн гоц халдварт шүлхий өвчний тандан судалгаа хийх ажлын	

	урьдчилан сэргийлэх, өвчний үед хэрэгжүүлэх арга хэмжээний төсөв төлөвлөгөөг гарган ажиллах.	тандан судалгааг хийн эрсдэлтэй газрын судалгааг гаргасан байна.			эмнэлгийн газар		гэрээг аймгийн Мал эмнэлгийн газартай байгуулсан. Дархан, Баян-Овоо, Батноров, Норовлин, Баян-Адрага, Дадал сумдын 6 газраас 12 цусны дээж, 30 цуллаг, 6 тунгалгийн булчирхайн дээж авсан.	100
4	Тухайн аймгийн хэмжээнд тусгай зориулалтаар агнасан амьтны тоо толгойн гүйцэтгэл, орон нутагт орсон орлогын тайланг ирүүлэх /2018 оны 11 дүгээр сарын 01-ний дотор/.	Тусгай зориулалтаар агнуулж бариулсан агнуурын амьтны тайлан хүргүүлсэн байна.	1 удаа	11 сард	БОАЖГ	0	БОАЖЯ-ны статистик мэдээллийн сангийн БОХ-6 тайлангаар 11 сард хүргүүлсэн.	100
5	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, нөхөн сэргээлт, аудитын эрх зүйн шинэчлэлийн талаарх болон бусад чиглэлийн сургалт сурталчилгааны ажил зохион байгуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийн хангах	Хууль бусаар ашигт малтмал олборлогч иргэдийг зохион байгуулалтад оруулсан байна.	2 удаа	5, 9-р сард	Швейцарын хөгжлийн агентлаг	15000,0	Тус аймгийн Галшар, Дархан, Бор-Өндөр, Цэнхэрмандал, Бэрх, Батноров, Норовлин, Баян-Адрага сумдын Бичил уурхайчдад, Бичил уурхайн нөхөн сэргээлт, Засгийн газрын 151 дугаар тогтоол, Хөдөлмөр аюулгүй ажиллагааны дүрэм журмын сургалтыг 5 дугаар сард зохион байгуулсан. Мөн 2018 оны 06 дугаар сард Хэнтий аймгийн уул уурхайн зөвлөгөөнийг зохион байгуулсан.	100
6	Агаарын чанарыг сайжруулах бүс тогтоох.	Чингис хотын агаарын бохирдлын судалгаатай болно.	1 багц	3-р сард	Грейн ази консалтинг ХХК	5000,0	Чингис хотын агаарын бохирдлын судалгааг хийлгэсэн. Ингэснээр агаарын бохирдол ямар шатандаа явж байгааг болон цаашид авах арга хэмжээг судлах боломж бүрдсэн.	100
7	Хог хаягдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.12 дэх “Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх	бүх нийтийн их цэвэрлэгээ, сургалт, сурталчилгаа зохион	2 удаа	4-10 сард	Сумдын ЗДТГ газар	-	“Хог хаягдлын тухай” хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Сумдад хог хаягдлын үйлчилгээний хөлсний төлбөр төвлөрдөг бөгөөд уг зардлаар хог хаягдлыг тээвэрлэхэд эргүүлэн	

	болон хог хаягдлыг ангилах, дахин ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагааг дэмжих, бүх нийтийн их цэвэрлэгээ, сургалт, сурталчилгаа зохион байгуулах үйл ажиллагаанд зарцуулагдах зардлыг аймаг, нийслэл, сум, дүүргийн төсөвт тусгаж зарцуулна.” гэж заасны дагуу хэрэгжүүлж ажиллах.	байгуулагдсан байна					зарцуулдаг болно. Аймгийн хэмжээнд жилдээ 3-4 удаа нийтийн цэвэрлэгээг зохион байгуулж ажилласан. 321 аж ахуйн нэгж, байгууллагын, 18400 өрхийн иргэдийг дээрх ажилд татан оролцуулсан бөгөөд 27.0 тн хог хаягдлыг цэвэрлэж, төвлөрсөн хог хаягдлын цэгт хуримтлуулсан.	100
3.Усны нөөцийн ашиглалт, хамгаалалтын чиглэлээр:								
8	Голын эхийн ойг нөхөн сэргээх, ойжуулах, урсац бүрэлдэх эхийг хамгаалах ажлыг зохион байгуулах.	Улз голын сав газарт төгөл байгуулагдсан байна.	Норовлин суманд 1удаа	5-р сард	Сумын ЗДТГ	950,0	Улз голын бага бүрдийн эхийг хашиж, 660 ширхэг мод бут тарьж, ногоон төгөл байгуулсан.	100
9	Аж ахуйн нэгж, байгууллагад усны тоолуур суурилуулах ажлыг зохион байгуулах.	усны тоолуур суурилуулагдсан байна	1 удаа	9 сард	Сумын ЗДТГ	-	Нийт 6 сумдын 17 аж ахуйн нэгжид 21 тоолуурыг Хэнтий-Ус ХХК суурилуулсан. Тухайн ААН-с хөрөнгө гаргуулсан.	100
10	Хэрлэн сумын төвд байрлах Улаан эргийн хөвийг сэргээн засварлах ажлыг гүйцэтгэх.	Даланг засварласан байна.	Хэрлэн суманд 1удаа	10-р сард	Сумын ЗДТГ	1200,0	Хэнтий-Ус ХХК-тай хамтран Нарийн голын тохой нэртэй газарт харьцуулсан нөхөн сэргээлтээр загас үржүүлгийн нуур цөөрмийн даланг хэлбэржүүлэх ажил хийгдсэн.	100
11	Бороо цасны усыг хуримтлуулах, бэлчээрийн мал аж ахуйн ус хангамжийг шийдэх зорилгоор шинээр хөв цөөрөм байгуулах ажлыг гүйцэтгэх, холбогдох газартай хамтран	Хөв цөөрөм байгуулагдсан байна.	2	жилдээ	БОАЖЯ, тухайн сумын	165000,0	Улсын төсвийн хөрөнгөөр Өмнөдэлгэр суманд хөв цөөрөм барих Хангалын голын эхэнд хийсэн. Боомтын урт 376м, өргөн 6м, өндөр 2м, налуу 1:3-тай, усыг шавхах зорилгоор 219 мм голчтой ган хоолой суурилуулсан. Гүйцэтгэгчээр Улаанбаатар хотын Велмот ХХК ажилласан.	100

	ажиллах, дэмжлэг үзүүлэх (тухай бүрт).							
12	Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийг олон нийтэд сурталчлах, хуулийг хэрэгжүүлэхэд оролцогч талуудыг мэргэжил, арга зүйгээр хангах сургалт, семинарыг хамтран зохион байгуулах.	Сургалт хийгдсэн байна.	1 удаа	3 сард	-	-	Хэрлэн голын СГЗ-тай хамтран сургалтыг Хэрлэн сумын 6 цэцэрлэг, 4 сургуулийн 800 орчим хүүхдэд “Усны үнэ цэнэ” сургалтыг зохион байгуулсан	100
4. Газар зохион байгуулалтын чиглэлээр:								
13	Орон нутгийн газар зохион байгуулалтын 2017 оны жилийн төлөвлөгөөнд газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг тусган хэрэгжүүлэх	10 газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийгдсэн байна.	1 багц	7-р сарын 15-аас 10-р сарын 1 өдөр	“Дэвжих дэлгэр эрхт” ХХК	15000,0	Дархан суманд хууль бус гар аргаар байгалийн өнгөт чулуу түүсэн иргэдийн нөлөөгөөр эвдэрсэн 10 га газарт техникийн нөхөн сэргээх ажлыг аймгийн Засаг даргын захирамжаар Дархан сумын Засаг даргын Тамгын газарт эрхийг шилжүүлж, тендер сонгон шалгаруулалтын ажил 2018 оны 06 дугаар сард зарлан “Дэвжих дэлгэр эрхт” ХХК шалгаран гүйцэтгэсэн.	100
14	Голын хамгаалалтын бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа, элс хайрганы карьер ашиглаж буй аж ахуйн нэгж байгууллагын газрын эрхийг цуцлах арга хэмжээг авах, нүүлгэн шилжүүлэх	-	-	-	-	-	Тус аймгийн хэмжээнд Голын хамгаалалтын бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа, элс хайрганы карьер байхгүй.	-

15	Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, ААНБ-д онцгой албан татвар ногдуулах замаар голд ойрхон газар эзэмшиж, ашиглах сонирхолыг хязгаарлах дүрэм журам гаргах, хэрэгжүүлэх					0	Аймгийн ИТХ-ын 2016.05.02-ны өдрийн 13 дугаар тогтоолоор Усан сан бүхий газар болох гол 129, 935 булаг, 417 нуур, 83 худагт онцгой болон энгийн, эрүүл ахуйн бүсийг тогтоон баталсан. Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, ААНБ-д хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдөхийг анхааруулж ажилласан.	100
5. Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр:								
16	Авто зам дагуу аялал жуулчлалын түр буудаллах үйлчилгээний цогцолбор байгуулах /А, Б, С ангиллын/. Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудад стандартын шаардлагыг нэмэгдүүлэх, мөрдүүлэх /Ажлын хэсэг байгуулж зочид буудал, амралтын газар, жуулчны бааз, гэр буудлуудад хяналт шалгалт хийн, дүн мэдээг хүргүүлэх/.	Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа жуулчны бааз, Зочид буудал, амралтын газрын стандарт сайжирч ажиллагсдын ур чадвар сайжирсан байна.	Шалгалтад -25 Зөвлөгөөн хэлэлцүүлэгт 150 хүн	2018.07.02	АЗДТГ, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар, Хэрлэн голын сав газрын захиргаа	0	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Чингис хаан брэнд дэд хөтөлбөрийн хүрээнд аялал жуулчлалын үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд стандартыг мөрдүүлэх хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэлээ.	1100
17	Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгжүүдэд сургалт, сурталчилгааны ажил хийх.	Нутгийн иргэд болон зочлох үйлчилгээний салбарын ажилчдын мэдлэг чадвар дээшилж аялал жуулчлалаас олох орлого нэмэгдсэн	НИТАЖ-ын сургалтад 25, Зочлох үйлчилгээ	НИТАЖ сургалт 2018 оны 8 сарын 26, Зочлох	АЗДТГ, БОАЖГ, Монголын Зочид буудлуудын холбоо		Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг ИТМ аялал жуулчлалын үзэсгэлэн, 6 сард зохион байгуулагддаг дотоодын аялал жуулчлалын үзэсгэлэн Ulaanbaatar expo аялал жуулчлалын үзэсгэлэнд аймаг орон нутгаа төлөөлөн оролцож буй аж ахуй нэгжүүдийг сургалтад хамруулахаас гадна ӨМӨЗО-ны Хөх хотод зохион	

		байна.	эний сургалт 50	үйлчилгээний сургалт 2018. 10-23-24		2250,0	байгуулагдсан Аялал жуулчлалын үзэсгэлэнд Хэнтий аймагт үйл ажиллагаа явуулдаг 6 жуулчны баазын бааз, 2 зочид буудал нэгдсэн зохион байгуулалттайгаар амжилттай оролцож Хөх хотын аялал жуулчлалын тур операторуудтай уулзалт хийж амжилттай оролцсон. Мөн Зочид буудлын захирал, менежер, ажилтан албан хаагчдын дунд Үйлчилгээний ажилтнуудыг чадавхжуулах, үйлчилгээний технологи сургалтыг Монголын зочид буудлуудын холбоотой хамтран зохион байгуулсан. Сургалтад аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг 10 зочид буудлын 45 хүн оролцсон. Мөн Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын сургалтыг Аялал жуулчлалын багш судлаачдын нийгэмлэг болон Мөнх Харилцаа төрийн бус байгууллагатай хамтран 2018 оны 8 сарын 26 нд зохион байгуулсан бөгөөд сургалтад нөхөрлөл болон иргэдийн төлөөлөл 25 хүн оролцсон.	100
18	Шинээр төлөвлөгдөж байгаа болон тогтворжсон эвент арга хэмжээ зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх, орчны бохирдлоос хамгаалах.	Хэнтий аймгийн түүх соёлыг эвент арга хэмжээгээр дамжуулан гадаад дотоод сурталчилсан байна.	5 эвент арга хэмжээ	2018 оны 6 сар, 7 сар, 8 сар 11 саруудад	АДЗТГ, Сумдын ЗДТГ, БОАЖГ, Холбогдох төрийн бус байгууллага	7000,0	2018 онд Хэнтий аймагт Тогорууны баяр, Галшар адууны баяр, Талын тайга нохойн наадам-2018, Талын түмэн адууны баяр зэрэг эвент арга хэмжээнүүд зохион байгуулагдсан ба уг арга хэмжээнүүдийг үзэхээр гадаадын 2000 гаруй дотоодын 5000 гаруй жуулчид ирсэн байна. Энэ арга хэмжээнүүдэд аймаг орон нутгийн зүгээс 8 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн ажиллаа.	100

